



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



ᠰᠠᠨᠬᠦᠭᠦᠭᠢᠨ
ᠵᠣᠬᠢᠴᠢᠭᠤᠯᠠᠬᠤ
ᠬᠣᠷᠤᠭ᠎ᠠ

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ 2020 ОН

АГУУЛГА

I. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зах зээлийн төлөв

8

Хүртээмжтэй байдал

10

Бүтээгдэхүүн үйлчилгээ

12

Ашигт ажиллагаа

15

Тогтвортой байдал

16

Бодлого зохицуулалт

17

II. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зах зээлийн төлөв

20

Хүртээмжтэй байдал

24

Бүтээгдэхүүн үйлчилгээ

27

Ашигт ажиллагаа

29

Тогтвортой байдал

30

Бодлого зохицуулалт

31

III. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Санхүүгийн зах зээлийн төлөв

36

Хүртээмжтэй байдал

40

Бүтээгдэхүүн үйлчилгээ

43

Ашигт ажиллагаа

47

Тогтвортой байдал

49

Бодлого зохицуулалт

51

IV. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Санхүүгийн зах зээлийн төлөв	Хүртээмжтэй байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Ашигт ажиллагаа	Тогтвортой байдал	Бодлого зохицуулалт
56	58	62	66	68	70

V. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Санхүүгийн зах зээлийн төлөв	Хүртээмжтэй байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Ашигт ажиллагаа	Тогтвортой байдал
74	75	77	78	79

VI. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ


Салбарын төлөв	Хүртээмжтэй байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Ашигт ажиллагаа	Бодлого зохицуулалт
82	83	84	86	87

VII. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

Салбарын төлөв	Хүртээмжтэй байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Ашигт ажиллагаа	Бодлого зохицуулалт
90	91	92	94	98

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНУ	Америкийн Нэгдсэн Улс	ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
АХБ	Азийн хөгжлийн банк	ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	МАPIX	Монголын хөдөө аж ахуйн барааны үнийн индекс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс	ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	AFI	Alliance for Financial Inclusion / Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг/
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас	ATM	Automated teller machine /Автомат теллер машин/
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү	ESG	Environmental, Social, Governance /Байгаль орчин, нийгэм, засаглал/
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ	JICA	Japan International Cooperation Agency /Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага/
МИК	Монголын ипотекийн корпораци	IAIS	International Association of Insurance Supervisors /Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо/
МХБ	“Монголын хөрөнгийн бирж” ХК	IPO	Initial public offering /Олон нийтэд хувьцаагаа санал болгох/
МҮЦБ	“Монголын үнэт цаасны бирж” ХК	FPO	Follow up on public offering /Нэмэлт хувьцаа гаргах/
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага	MSE	Mongolian stock exchange /Монголын хөрөнгийн бирж/
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо	UNEP FI	Нэгдсэн үндэсний байгууллагын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүжилтийн санаачилга
ТДЦА	Татварын дараах цэвэр ашиг		
ТЗК	Тусгай зориулалтын компани		
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци		
ҮХЭХЗ	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал		
ҮЦК	Үнэт цаасны компани		
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв		
ХАА	Хөдөө аж ахуй		
ХЖДХ	Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү		
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо		
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө		
ХК	Хувьцаат компани		
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс		





ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн үнэлгээ

3,029.7
тэрбум төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Дансны тоо
2,385,822



Хүртээмжтэй байдал

Нийт арилжааны дүн
65.4 тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



ҮЦК-ийн хөрөнгө

112.5

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



ТОП-20 индексийн
хэлбэлзэл

1,022.7

Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ




Үнэт цаасны зах зээлд нийт **591** зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байна

Арилжаа эрхлэх 2	Төвлөрсөн хадгаламж, үнэт цаасны арилжааны төлбөрийн 1	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэл хянагч 1
ХОМК 23	Тооцооны 1	Кастодиан 3
Андеррайтерийн зөвшөөрөлтэй банк 2	Хөрөнгө итгэмжлэн удирдах 7	ХК 315
ҮЦК* 53	ХАА түүхий эдийн арилжаа эрхлэх 1	ХАА түүхий эдийн брокер 14
ҮЦЗЗ-д аудитын үйлчилгээ үзүүлэх 59	ҮЦЗЗ-д хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх 25	ҮЦЗЗ-д хуулийн үйлчилгээ үзүүлэх 34
Үнэт цаасны итгэмжлэн удирдагч 1	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч 27	Хөрөнгө оруулалтын сан 22

*ҮЦК-д брокер, дилер, андеррайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг хамаатуулна.

Үнэт цаасны арилжаа /тэрбум төгрөг/




Үнэт цаасны зах зээлийн арилжаа


- 2020 онд нийт 65.4 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжаалагдсан бөгөөд 2019 оноос 54.5 хувиар, 2016 оноос 81.3 хувиар буурсан.
- 2020 онд нийт арилжааны 0.9 хувийг ЗГҮЦ, 7.8 хувийг хөрөнгө оруулалтын сан, 8.9 хувийг компанийн бонд, 82.4 хувийг хувьцаа тус тус эзэлж байна.

Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар

- Нийт зах зээлийн үнэлгээ 2019 оноос 12.5 хувиар, 2016 оноос 105.5 хувиар өсөж 3.0 их наяд төгрөгт хүрсэн бол хөрвөх чадвар 2019 оноос 3.2 пунктээр буурч 1.8 хувьд хүрлээ.
- 2020 онд хөрвөх чадвар буурахад хувьцааны арилжааны хэмжээ 79.8 тэрбум төгрөгөөр буюу 59.7 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.



ЗЗУ/ДНБ /хувиар/



- Монголын Үнэт цаасны зах зээлийн үнэлгээг ДНБ-д харьцуулсан дүнг FTSE жагсаалтад багтах frontier зах зээлийн улс орнуудтай харьцуулахад 3 дугаарт жагсаж байна. Энэ нь бусад ижил төстэй орнуудтай харьцуулахад харьцангуй доогуур үзүүлэлт юм.



ТОП 20 19,285.8

MSE A 9,122.0


MSE Б 7,581.1

Үнэт цаасны зах зээлийн индекс

- ТОП-20 Индекс өмнөх онтой харьцуулахад 336.1 нэгжээр буюу 1.7 хувиар буурсан.
- MSE A индекс өмнөх оноос 409.7 нэгжээр буюу 4.3 хувиар буурсан.
- MSE Б индекс өмнөх оноос 369.6 нэгжээр буюу 4.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




ХААБ-ээр нийт 488.7 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оноос 216.3 тэрбум төгрөгөөр буюу 30.7 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд 5 төрлийн бүтээгдэхүүн арилжигджээ.



ХАА-н биржийн MAPIX индекс

ХААБ-ээс тооцон гаргадаг Монголын хөдөө аж ахуйн индекс буюу MAPIX 2020 онд 918,691.4 нэгжид хүрсэн нь 2019 онтой харьцуулахад 124,375.3 нэгжээр буюу 15.7 хувиар, 2016 онтой харьцуулахад 86.3 хувиар өссөн.




ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ТОП-20 ИНДЕКСЭД БАГТАХ ХК-УУДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ /ЗЗҮ-ЭЭР/



ХУВЬЦААНЫ ТӨВЛӨРӨЛ

- ТОП 20 индексэд ХК-уудын төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 80.3 хувийг нийт хувьцаа эзэмшигчдийн 0.05 хувь нь эзэмшиж байна.

**5-аас доош хувь эзэмшигч**

Хувьцааны **19.7%** хувийг **99.95%** нь эзэмшиж байна



НЭЭГДСЭН ДАНСНЫ ТОО



- 2020 онд 558,098 данс нээгдэж нийт дансны тоо 2,385,822-т хүрсэн бол 159,559 холболтын данс нээгдэж холболтын дансны тоо 377,434-т хүрлээ
- 2019 онтой харьцуулахад нийт дансны тоо 30.5 хувиар нэмэгдсэн.



НИЙТ НЭЭГДСЭН ДАНСНЫ ТОО
/ӨССӨН ДҮНГЭЭР/


2,385,822

ҮЦТХТ-Д БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС



ҮЦК БОЛОН ХАА-Н БРОКЕРЫН КОМПАНИУДЫН БАЙРШИЛ

- 2020 онд нийт 53 ҮЦК болон тэдгээрийн 30 салбар үйл ажиллагаа явуулав. Эдгээрийг газар зүйн байршлаар харуулбал 56 нь Улаанбаатар хотод, 27 нь орон нутагт байршиж байна.
- 2020 онд нийт 14 ХАА-н брокер үйл ажиллагаа явуулж байгаагийн 10 нь Улаанбаатар хотод, 4 нь орон нутагт байршиж байна.



БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

- 2020 онд нийт хувьцааны арилжаа 53.9 тэрбум төгрөгт хүрсэн нь 2019 онтой харьцуулахад 59.7 хувиар буурч, 2016 онтой харьцуулахад 9.9 хувиар өсжээ.



ЗГҮЦ–НЫ АРИЛЖАА

- 2020 онд ЗГҮЦ–ны арилжаа 0.6 тэрбум төгрөгт хүрсэн нь 2019 онтой харьцуулахад 93.9 хувиар, 2016 онтой харьцуулахад 99.8 хувиар тус тус буурчээ.



КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖАА

- 2020 онд компанийн бондын арилжаа 5.8 тэрбум төгрөгт хүрсэн нь 2019 онтой харьцуулахад 29.0 дахин өсөж, 2017 онтой харьцуулахад 1.8 дахин буурчээ.



Үндэсний
хувьчлалын сан

4.8
тэрбум төгрөг

Монголын хамгийн анхны олон нийтэд нээлттэйгээр биржээр арилжаалагдаж буй хөрөнгө оруулалтын сан бүртгэгдэв.

29
ТЗК

4.5
ИХ НАЯД
ТӨГРӨГ


ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

- Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох зорилгоор 2013 оноос ипотекийн бага хүүтэйгээр орон сууцны зээлийг иргэдэд олгож эхэлсэн. Өнөөгийн байдлаар “МИК ОССК” ХХК-аас 24 ТЗК үүсгэн байгуулж, нийт 83,674 зээлдэгчийн ипотекийн зээлийг үнэт цаасжуулж 4.4 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг СЗХ-нд бүртгүүлээд байна.
- Монгол Улсад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг үл хөдлөх хөрөнгийн зээлээр баталгаажуулж ирсэн бөгөөд 2020 оны байдлаар нийт 64,553 зээлдэгчийн 3.0 их наяд төгрөгийн баталгаат үнэт цаас байна.
- Үүрэн телефоны оператор болох “ЖиМобайл” ХХК хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан нь үл хөдлөх хөрөнгийн зээлээс өөр төрлийн санхүүгийн хэрэгслээр баталгаажсан үнэт цаас гаргасан анхны тохиолдол болсон.
- Ковид цар тахлын онцгой нөхцөлд ажиллаж буй төрийн албан хаагчдыг түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцны хөтөлбөрт хамруулах хүрээнд түрээсийн орлогод суурилсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, шаардлагатай санхүүжилтийн шийдвэрлэхийг хууль болон УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолоор ЗГ, Монголбанк, СЗХ-нд даалгасан. СЗХ-ноос “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийн үүсгэн байгуулсан “НОСК нэг” ХХК-д түрээсийн орлогоор баталгаажсан буюу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг олгож, орон сууцны түрээсээр баталгаажсан 34.4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн. Мөн СЗХ-ноос “НОСК хоёр” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг олгоод байна.
- Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжүүлэх дэд арга хэмжээний 1.4.1-д “Уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрийн салбарын зээлдэгчид бага хүүтэй зээл олгох нөхцөлийг банкнаас олгосон хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах, уг үнэт цаасыг барьцаалан Төв банкны репо санхүүжилтийг 1–2 жилийн хугацаатай, бодлогын хүүтэй ойролцоо хүүтэй санхүүжилтийн эх үүсвэр олгох” арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан. Энэхүү ажлын хүрээнд “Монголын актив удирдлагын корпораци”^{*} ХХК-д хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрлийг олгосон. Улмаар “Монголын актив удирдлагын корпораци” нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ТЗК буюу “МҮЦСК” ХХК-ийг үүсгэн байгуулсан бөгөөд “МҮЦСК” ХХК-д Хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон.
- СЗХ-ноос “Инвескор актив” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг олгож, бүртгэсэн нь банк бус санхүүгийн байгууллагуудын зээлээр баталгаажсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан олон нийтэд анх удаа нээлттэй арилжаалах анхны тохиолдол болсон.

* “Монголын актив удирдлагын корпораци” ХХК нь оноосон нэрээ өөрчлөн “Үнэт цаас санхүүжилтийн корпораци” ХХК болгосон.

АРИЛЖААНЫ БҮТЭЦ /ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДААР/

- Арилжаанд оролцогчдын дийлэнх хувийг дотоодын аж ахуйн нэгж эзэлсэн хэвээр байгаа бөгөөд 2020 оны байдлаар дотоодын ААН-ийн хийсэн арилжааны гүйлгээ хамгийн их буюу 57.1 хувь байна.



○ Дотоодын ААН, 57.1%


● Гадаадын ААН, 0.5%

○ Дотоодын иргэн, 29.4%

● Гадаадын иргэн, 13.0%

ХУВЬЦААНЫ ӨМЧИЙН БҮТЭЦ

- 2020 оны байдлаар СЗХ-ны үнэт цаасны бүртгэлд нийт 315 ХК бүртгэлтэй байна.
- Өмчийн бүтцийг задлан харвал нийт ХК-ийн 85.7 хувь нь хувийн өмчит, 11.1 хувь нь төрийн өмчит, 3.2 хувь нь төрийн өмчийн оролцоотой байна.




○ Хувийн өмчит 85.7%

● Төрийн өмчит оролцоотой 3.2%

○ Төрийн өмчит 11.1%

АШИГТ АЖИЛЛАГАА




ҮЦК-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- ҮЦК-уудын нийг хөрөнгө 2020 онд 112.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 16.2 хувиар өссөн үзүүлэлт юм.
- Өмнөх онтой харьцуулахад орлого 0.7 тэрбум төгрөгөөр, зардал 0.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол цэвэр ашиг 0.5 тэрбум төгрөгөөр буурчээ.


ҮЦК-ИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ

● Брокерын үйл ажиллагааны орлого	45.9%
● Андеррайтерийн үйл ажиллагааны орлого	24.1%
● Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааны орлого	7.6%
● Хүүгийн орлого	7.3%
● Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	6.0%
● Бусад ашиг, орлого	5.9%
● Ногдол ашгийн орлого	1.2%
● Түрээсийн орлого	1.1%
● Дилерийн үйл ажиллагааны орлого	0.7%
● Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.2%



ҮЦК-ИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ



● Борлуулалт, маркетингийн болон ерөнхий удирдлагын зардал	78.5%
● Санхүүгийн зардал	11.7%
● Бусад зардал	1.8%
● Орлогын татварын зардал	1.9%
● Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах алдагдал	6.1%
● Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	0.02%



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ТОП-20 ИНДЕКСИЙН ХЭЛБЭЛЗЭЛ

- Хувьцааны үнийн хэлбэлзлийг ТОП-20 индексийн хүрээнд тооцон гаргалаа. Хувьцааны үнийн хэлбэлзэл 2020 онд 1,022.7 нэгж байгаа нь өмнөх оноос 25.2 пунктээр өссөн үзүүлэлт юм.



MSE A БОЛОН MSE Б ИНДЕКСИЙН ХЭЛБЭЛЗЭЛ

- Хувьцааны үнийн хэлбэлзлийг MSE A болон MSE Б индексүүдийн хувьд тооцож үзэхэд 2020 онд MSE A индексийн хэлбэлзэл 97.3 пунктээр өссөн, MSE Б индексийн хэлбэлзэл 202.2 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.

IPO ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ

- 2005 оноос хойш нийт 24 компани IPO хийж 139.8 тэрбум төгрөгийн хөрөнгийг анхдагч зах зээлээс амжилттай татан төвлөрүүлсэн байна.



FPO ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ

- Монголын анхны Follow on Public Offering (FPO) буюу нэмж хувьцаа гаргах замаар хөрөнгө татан төвлөрүүлэх арилжаа 2007 онд явагдаж байв. 2007 оноос хойш давхардсан тоогоор 9 компани 11 удаагийн арилжаагаар нийт 39.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг нэмэлт хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлжээ. 2020 онд нэг компанид нэмж хувьцаа гаргах зөвшөөрөл олгосон.

КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

- Монголд бондын анхдагч зах зээлийн арилжаа анх 2001 онд явагдаж байв. 2001 оноос хойш 2020 он хүртэл давхардсан тоогоор 15 компани 17 удаагийн арилжаагаар нийт 30.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүллээ.



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

o JICA-тай хамтран "Монгол Улсын Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх" төслийн 2-р үе шатыг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд биржийн бус арилжааны эрх зүйн зохицуулалт, компанийн бондын зах зээлийг хөгжүүлэх, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох чиглэлээр хамтран ажиллаж байна. Төслийн хүрээнд биржийн бус арилжааны эрх зүйн зохицуулалт, тогтолцооны зарчмыг тодорхойлж, журмын төслийг боловсруулж зах зээлийн оролцогч байгууллагуудын саналыг авч ажилласан. Улмаар СЗХ-ны 2020 оны 995 дугаар тогтоолоор "Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам"-ыг баталсан.

- o OУСК-тай хамтран "Монгол Улсад Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд байгальд орчинд ээлтэй бизнесийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар дотоодын хөрөнгийн зах зээл дээрээс урт хугацааны санхүүжилт татахад хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, зохицуулалтын бодлогоор дэмжих, мөн ESG-ын олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

o СЗХ-ны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр "Үнэт цаасны дараа төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлэх тухай" 29 дүгээр тогтоолыг баталсан. Үүний хүрээнд дэд бүтцийн байгууллагуудын холбогдох журмуудыг батламжлах, тусгай зөвшөөрлийг нэмж олгох зэрэг үнэт цаасны зах зээлд төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлэх бэлтгэл ажлуудыг хангаж, дээрх зарчмыг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хөрөнгийн зах зээлд амжилттай нэвтрүүлсэн.

- o УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Зээлийн хүүг бууруулах стратеги"-ийн 4-т тусгагдсан "Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах" арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсгийг СЗХ-ны дарга, Сангийн сайдын хамтарсан тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгийн хүрээнд хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл хураамжийг бууруулах, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлж дэмжих, компанийн бондын биржийн бус зах зээлийг хөгжүүлэх, хөндлөнгийн үйлчилгээ үзүүлэгч мэргэжлийн байгууллагуудыг чадавхжуулах, банкний хөрөнгийн зах зээлд оролцох боломжийг нэмэгдүүлэх зэрэг үндсэн 8 чиглэлийн хүрээнд санал, дүгнэлтийг гарган ажилласан.
- o СЗХ-ны 2019 оны 4 дүгээр тогтоолоор баталсан "Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм"-ийн нэгдүгээр хавсралт "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ыг үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх хүрээнд мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номинал дансны зохицуулалтын орчинг тусган шинэчлэн боловсруулж, СЗХ-ны 2020 оны 1,014 дүгээр тогтоолоор батлуулсан.
- o Монголын хөрөнгийн бирж дээр давхар бүртгэлтэй компанийн хувьцаа эзэмшиж байгаа иргэд хувьцаагаа гадаадын хөрөнгийн бирж рүү хөрвүүлэх боломжийг бий болгох чиглэлээр СЗХ-ны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компани гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

o JICA-тай хамтран "Монгол Улсын Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх" төслийн 2-р үе шат хэрэгжиж эхэлсэн. Үүний хүрээнд "Компанийн бондын зах зээлийн хөгжил болон зохицуулалтын орчин" сэдэвт хэлэлцүүлгийг 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр хамтран зохион байгуулав. Уг хэлэлцүүлэгт СЗХ, JICA-ийн мэргэжилтнүүд, хөрөнгийн зах зээлийн оролцогчид, эдийн засагчид, судлаачид, хөрөнгө оруулагчид, үндэсний томоохон компаниуд, хэвлэл мэдээллийнхэн оролцсон.

- o СЗХ-ноос "Нээлттэй нийгэм форум"-той хамтран "Хувьцаат компанийн комплайнс, мэдээллийн ил тод байдал" хэлэлцүүлгийг 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан бөгөөд хувьцаат компаниуд, санхүүгийн бусад салбарын оролцогч байгууллагууд, мэргэжлийн холбоод, эрдэмтэн судлаачид зэрэг 140 гаруй төлөөлөл оролцсон. Тус хэлэлцүүлгээр хувьцаат компаниудын засаглалын чанарыг сайжруулах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах мөн хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгох, санхүүжилтийн зардлыг бууруулах чиглэлээр СЗХ-ноос авч хэрэгжүүлж буй бодлогын томоохон арга хэмжээнүүдийг танилцуулсан.
- o OУСК-аас СЗХ-той хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсад Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд 2020 оны 6 дугаар сарын 19-ний өдөр "Ногоон бондын зах зээлийг хөгжүүлэх нь" сэдэвт семинар хэлэлцүүлгийг олон нийтэд нээлттэй зохион байгуулсан.



ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Нийт хөрөнгө

382.1 тэрбум төгрөг

Хөрөнгийн өсөлт **4.6%**



Санхүүгийн зах зээлийн төлөв

Даатгалын нягтрал

61,117 төгрөг

Нягтралын өсөлт
0.7%



Хүртээмжтэй байдал

Зуучилсан даатгалын
болон давхар даатгалын
хураамж

54.4 тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ



Ашигт ажиллагаа



Цэвэр ашиг
21
тэрбум төгрөг



Тогтвортой байдал



Давхар даатгалын
хураамжийн зардал
33.1%

Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ

СЗХ–ноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн бүртгэлийн хүрээнд тайлант онд нийт 319 /давхар даатгалын зуучлагч ороогүй болно/ даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, аудитор мөн 2,473 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа явуулсан.





* Давхар даатгалын зуучлагч давхардсан тоогоор орсон болно.

ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ

2020 онд даатгалын гүнзгийрэлт 0.57 хувьд хүрч өмнөх онтой харьцуулахад 0.01 хувиар, 2016 онтой харьцуулахад 0.09 хувиар тус тус өссөн байна.

2019 онд дэвшилтэт зах зээлтэй улс орнуудын даатгалын дундаж гүнзгийрэлтийн түвшин 9.6 хувь байсан бол шинээр гарч ирж буй зах зээлтэй улс орнуудын даатгалын дундаж гүнзгийрэлтийн түвшин 3.3 хувьтай байсан байна.




ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ

- Тайлант онд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 4.5 хувиар өсөж 382.1 тэрбум төгрөгт хүрсэн бол 2016 оноос 83.3 хувиар өсжээ.
- Эрдийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ бусад даатгалын төрөлтэй харьцуулахад өмнөх оноос 12.8 хувиар өсөж 317.0 тэрбум төгрөг хүрч, салбарын нийт хөрөнгийн 83 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх онтой харьцуулахад 26.8 хувиар буурч, 55.2 тэрбум төгрөг хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 14.4 хувийг эзэлж байна. 2020 оны 1 дүгээр улиралд 1 давхар даатгалын компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотойгоор давхар даатгалын хөрөнгийн өсөлт өмнөх онтой харьцуулахад буурсан юм.
- Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 6.1 хувиар өсөж, 9.9 тэрбум төгрөгт хүрч, салбарын 2.6 хувийг эзэлж байна.


ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БҮТЭЦ /НИЙТ ХӨРӨНГӨӨР/

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн бүтцийг авч үзвэл 17.4 тэрбум төгрөг буюу 4.5 хувийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, 231.3 тэрбум төгрөг буюу 60.5 хувийг хөрөнгө оруулалт, 32.2 тэрбум төгрөг буюу 8.5 хувийг үндсэн ба биет бус хөрөнгө /цэвэр дүн/, 26.5 хувийг бусад хөрөнгө бүрдүүлж байна.



Даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзэлж буй хувиар нь авч үзвэл 9 хувиас дээш хувийг 3 даатгалын, 6–9 хувийг 6 даатгалын, 3–6 хувийг 2 даатгалын, 3 хувиас доош хувийг 5 даатгалын, үйл ажиллагааг зогсоосон 2 компани бүрдүүлж байна.


Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь




ДААТГАЛЫН КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН ӨСӨЛТИЙН ТАРХАЛТ

Нийт даатгалын компаниудын хөрөнгийн дундаж өсөлт 2019 онд 9.4 хувь байсан бол тайлант онд 15 хувьтай байна. Харин хөрөнгийн өсөлтөөр бүлэглэвэл 30 хувиас дээш өсөлттэй 4, 20–30 хувийн өсөлттэй 1, 10–20 хувийн өсөлттэй 2, 10 хувиас доош өсөлттэй 6, нийт хөрөнгийн хэмжээ буурсан 3 компани байна.

2019 / 2020



- Ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж
- Ердийн болон урт хугацааны даатгалын давхар даатгалын хураамж
- Дотоодын давхар даатгалын компанийн нийт хураамж




НИЙТ ХУРААМЖ

- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 2020 онд нийт 201.5 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлжээ. Үүнээс: ердийн даатгалын компаниуд 200 тэрбум төгрөг буюу 99.3 хувь, урт хугацааны даатгалын компани 1.5 тэрбум төгрөг буюу 0.7 хувийг бүрдүүлжээ.
- Нийт 66.8 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулсны 3.6 тэрбум төгрөг буюу 5.3 хувийг дотоодын давхар даатгагчид төлжээ.
- 2020 оны ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж өмнөх онтой харьцуулахад 2.5 хувиар өсжээ. Харин 2016 онтой харьцуулахад 78.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ДААТГАЛЫН БОЛОН ДАВХАР ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

- Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2020 онд 59.8 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн онтой харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 8.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Харин 2016 онтой харьцуулахад 74.5 хувиар өсжээ.
- Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 99 хувийг бүрдүүлжээ.
- Тайлант хугацаанд давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн хэмжээ 50 хувиар буурч 5.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.



НӨӨЦ САН

- Даатгалын салбарын нийт нөөц сангийн хэмжээ тайлант онд өнгөрсөн оноос 4.8 хувиар өсөж 173.5 тэрбум төгрөгт хүрсэн.
- Тайлант онд ердийн даатгалын компаниудын нийт нөөц сангийн хэмжээ өнгөрсөн онтой харьцуулахад 8.7 хувиар өсөж 144.1 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компанийн нөөц сан 22 хувиар өсөж 2.8 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн нөөц сан 13.6 хувиар буурч 26.6 тэрбум төгрөг болов.

173.5

Тэрбум төгрөг
2020

165.6


Тэрбум төгрөг
2019



ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ДААТГАЛЫН НЯГТРАЛ

Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлдэг.



- Даатгалын нягтрал 2020 онд 61,117 төгрөг болж 2019 онтой харьцуулахад 0.7 хувиар, 2016 онтой харьцуулахад 68.8 хувиар тус тус өссөн байна.
- Даатгалын нягтралыг ангиллаар авч үзвэл, нэг хүнд ногдох ердийн даатгалын хураамж 0.6 хувиар өсөж 60,668 төгрөг болсон бол урт хугацааны даатгалын хураамж 14.2 хувиар өсөж 449 төгрөгт хүрсэн байна.
- 2019 онд дэвшилтэт зах зээлтэй улс орнуудын даатгалын дундаж нягтралын түвшин 4,664 ам.доллар байдаг бол шинээр гарч ирж буй зах зээлтэй улс орнуудын даатгалын дундаж нягтралын түвшин 175 ам.доллартой байсан байна.

ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ТОО

2020 оны байдлаар нийт 1.1 сая даатгалын гэрээ байгуулагдсан байна. Үүнээс 82.9 хувь буюу 913,886 нь хувь хүнтэй байгуулсан даатгалын гэрээ байгаа бол 17.1 хувь буюу 188,943 нь хуулийн этгээдтэй байгуулсан даатгалын гэрээ байв.

ХУВЬ ХҮН **913,886**

ХУУЛИЙН
ЭТГЭЭД **188,943**



Даатгалын үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч өөр нэгэн үзүүлэлт нь даатгалын компанийн салбар, зуучлагчдын тоо юм. Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компаниудын нийт 2,230 салбар, төлөөлөгчийн газар 21 аймагт байршиж байна. Эдгээр салбарыг бүсээр ангилбал хангайн бүсэд хамгийн их буюу 703, төвийн бүсэд 668, баруун бүсэд 574, зүүн бүсэд хамгийн бага буюу 285 салбар, төлөөлөгчийн газар тус тус үйл ажиллагаа явуулж байна.



ТӨЛӨӨЛӨГЧИД


500

605

522

237

- Тайлант хугацаанд Улаанбаатар хотод нийт даатгалын компанийн 47, даатгалын зуучлагчийн 183, хохирол үнэлэгчийн 41 салбар СЗХ-нд бүртгэлтэй байна.
- Эдгээрийг дүүргээр ангилан үзвэл салбар нэгжийн 93 хувь нь төвийн 6 дүүрэгт төвлөрчээ.
- Түүнчлэн СЗХ-нд бүртгэлтэй даатгалын компанийн төлөөлөгчийн газар 12 байгаагаас БНХАУ-д нэг төлөөлөгчийн газар байна.



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ



- Ердийн болон урт хугацааны даатгалын нийт 23 хэлбэрээс “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал”-аас бусад нь сайн дурын даатгалын хэлбэр юм.
- Давхардсан даатгалын бүтээгдэхүүний тоо 2019 онтой харьцуулахад 40–р нэмэгдэж 632 болов. 2016 онд 541 бүтээгдэхүүн буюу 91–ээр бага байсан байна.

Даатгалын нийт хураамж



Даатгалын нөхөн төлбөр




АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нийт хураамж тайлант онд 34.6 тэрбум төгрөгт хүрч, нийт даатгалын хураамжийн орлогын 17.2 хувийг эзэлж байна. Нөхөн төлбөрийн хувьд өнгөрсөн оноос 8.9 хувийн бууралттай байна.
- Энэ онд 17.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр тус хэлбэрээр олгосон нь салбарын нийт нөхөн төлбөрийн зардлын 29.3 хувийг бүрдүүлжээ.



ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИД

- 2020 онд даатгалын зуучлагчдын төвлөрүүлсэн даатгалын болон давхар даатгалын хураамж 54.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин даатгалын зуучлагчдын зуучлалын шимтгэлийн орлого өнгөрсөн онд 10.5 тэрбум төгрөг байсан бол тайлант онд 648.3 сая төгрөгөөр өсөж 11.1 тэрбум төгрөгт хүрэв.



ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИД


- Тайлант онд даатгалын хохирол үнэлэгч компаниуд нийт 28,314 хохирлыг 26.4 тэрбум төгрөгөөр үнэлэв. Нийт даатгалын хохирол үнэлгээний орлого өнгөрсөн онтой харьцуулахад 11.7 сая төгрөгөөр буурч, 1.1 тэрбум төгрөгт хүрэв.



АШИГТ АЖИЛЛАГАА



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ЦЭВЭР АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- Тайлант онд даатгалын компаниудын цэвэр ашиг өнгөрсөн онтой харьцуулахад 1.7 тэрбум төгрөгөөр буурч 21 тэрбум төгрөгт хүрсэн. Харин 2016 онтой харьцуулахад 83.8 хувиар өссөн байна.
- Татварын дараах цэвэр ашгийн өсөлтийг бүлэглэн авч үзвэл цэвэр ашгийн хэмжээ буурсан 7, 50 хувь хүртэлх өсөлттэй 3, 50–100 хувийн өсөлттэй 2, 100 хувиас дээш өсөлттэй 4 даатгалын компани байна.



ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД

- Хохирол нөхөлтийн харьцаа тайлант онд өнгөрсөн онтой харьцуулахад 5.9 пунктээр буурсан үзүүлэлттэй байв.
- Зардлын харьцаа өмнөх оноос 1.1 пунктээр өсөж 45.7 хувь болжээ.
- Даатгалын салбарын цэвэр ахиуц ашгийн харьцаа тайлант онд 1.2 пунктээр буурч 10.2 хувьд хүрлээ.



АШИГТ АЖИЛЛАГААНЫ КОЭФФИЦИЕНТ

- Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 2019 онд 5.23 хувьтай байсан бол 2020 онд 6.5 пунктээр өсөж 11.7 хувьд хүрлээ. Нийт хөрөнгийн өгөөжийн хувьд 2019 онд 2.5 хувьтай байсан бол 2020 онд 2.9 пунктээр өсөн 5.4 хувьд хүрлээ.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

- Монгол Улсын даатгалын зах зээлийн тулгамдаж буй асуудлын нэг нь валютын ханшийн эрсдэл юм.
- Даатгалын компаниудын дийлэнх нь гадаад улсад давхар даатгуулдаг бөгөөд сүүлийн гурван жилийн хугацаанд 1 жилд дунджаар 50 гаруй тэрбум төгрөгийг гадаад улс руу шилжүүлсэн.
- Даатгалын компаниудын гадаад улсад төвлөрүүлсэн давхар даатгалын хураамж ийн зардал тайлант онд даатгалын нийт хураамжийн 33.1 хувьтай тэнцэж байна.

33.1%

Давхар даатгалын
хураамжийн нийт
хураамжид
эзлэх хувь


- Тайлант онд даатгалын компаниудын нийт хөрөнгийн 60.5 хувийг хөрөнгө оруулалт, үүний 88.3 хувийг хадгаламж, хадгаламжийн сертификат хэлбэрээр хийсэн хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.
- Хадгаламж, хадгаламжийн сертификат болон үнэт цаасаарх хөрөнгө оруулалтаас даатгалын компаниуд 2020 онд нийт 16.9 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон байна.

Хөрөнгө
оруулалтын
дүн
60.5%

Давхар даатгалын хураамж



Даатгалын нийт хөрөнгө оруулалт ба хадгаламжийн жигнэсэн дундаж хүү



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

o ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), Хүртээмжтэй даатгалын асуудлаарх Азийн орнуудын мэдлэг туршлага солилцох сүлжээ (MEFIN)–тэй хамтран 2020 оны 9 дүгээр сарын 29, 30–ны өдрүүдэд “Уур амьсгалын болон гамшгийн цар тахлын эрсдэлийг бууруулах нь” сэдвийн хүрээнд цахим хэлбэрээр MEFIN–ий гишүүн болон бусад холбогдох байгууллагын нийт 70 орчим даатгалын салбарын мэргэжилтэн, зохицуулах байгууллагын төлөөлөл, зочин илтгэгчид оролцсон Төр–Хувийн хэвшлийн Олон улсын зөвлөлдөх ээлжит 9 дүгээр уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулагдсан ба Монгол Улсаас СЗХ, Онцгой байдлын ерөнхий газрын албан хаагчид болон Монголын даатгалын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбооны төлөөллүүд оролцож мэдлэг, туршлагаа солилцлоо.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийн үзэл баримтлал батлагдсан.

o Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж, хуулийн төслүүдийн үзэл баримтлалын төсөлд Сангийн яаманд тухай бүр саналыг хүргүүлж ажилласан бөгөөд 2020 оны 4 дүгээр сард эдгээр хуулиудын төслийн үзэл баримтлал батлагдсан.

Хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоог бий болгох хүрээнд холбогдох хуулийн төслүүдэд санал хүргүүлж ажиллав.

o Азийн хөгжлийн банкны ажлын хэсгээс боловсруулсан Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон УИХ–ын гишүүн Н.Учралын санаачилсан “Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөл”–д тухай бүр холбогдох саналыг хүргүүлж ажилласан.

“Даатгалын багц дүрэм”–ийн холбогдох журам, зааврыг шинэчилж, нэмэлт, өөрчлөлт оруулав:

o Даатгалын зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг илүү ёс зүйтэй, шударга өрсөлдөөнтэй болгох замаар даатгуулагч олон нийтийн даатгалын салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилго бүхий “Даатгалын зах зээлийн ёс зүйн журам”–ыг шинэчлэн боловсруулж СЗХ–ны 2020 оны 114 дүгээр тогтоолоор баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн.

Хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр “Даатгалын багц дүрэм”–ийн холбогдох дүрэм, журмыг шинэчлэн найруулав.

o СЗХ–ны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”–ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам” болон дөрөвдүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх

хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулсан.


Шинэчлэгдэн батлагдсан эрх зүйн орчинтой нийцүүлэн холбогдох журам, заавруудыг шинэчлэн боловсруулж, батлуулж, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж ажиллав. Үүнд:

- Сангийн сайд, СЗХ-ны даргын хамтарсан 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 6/10 тоот тушаалаар “Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам”-ыг, 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 5/11 тоот тушаалаар “Малын индексжүүлсэн даатгалын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журам”-ыг тус тус шинэчлэн баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4673, 4674 дугаарт бүртгүүлсэн.
- СЗХ-ны 2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 165, 166 дугаар тогтоолоор “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын мэдүүлгийн маягт, гэрээний стандарт, загварт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тус тус баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3947, 3948 дугаарт тус тус бүртгүүлсэн.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

○ 2020 оны 10 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хүрээнд “Даатгалын салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд өртөмтгий байдлын үнэлгээ” болон “Хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүний мөнгө угаах эрсдэлийн үнэлгээ”-ний танилцуулгыг салбарын оролцогчдод болон холбогдох байгууллагуудад танилцуулж, үнэлгээний хэлэлцүүлгийг зохион байгуулсан.





БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Нийт хөрөнгө

2.0

их наяд төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Хөрөнгийн өсөлт

16.0%

Дундаж зээлийн хэмжээ

1.7 сая төгрөг

Харилцагч

2.8 сая



Хүртээмжтэй байдал

Зээлийн ББСБ

92.7%

7.3%

Зөвхөн гадаад валютын
арилжааны ББСБ



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт орлого

408.8

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Z индекс

33.0

Чанаргүй зээлийн нийт
зээлд эзлэх хувь

10.3%

Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

- 2020 онд СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр 532 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулав.
- Энэ нь өмнөх оноос 1.1 хувиар буурсан, 2016 оноос 2.7 хувиар өссөн үзүүлэлт юм.





Нийт банк бус санхүүгийн байгууллагуудын 5.5 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтаар, 94.5 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай байна.



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГӨ

2020 онд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 2.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 276.8 тэрбум төгрөгөөр буюу 16.0 хувиар, 2016 оноос 1.2 их наяд төгрөгөөр буюу 154.9 хувиар өсжээ.





ББСБ-уудын активын бүтэц /тэрбум төгрөгөөр/

Нийт хөрөнгийн дүн	2,006.9	100.0%
Эргэлтийн хөрөнгө	1,927.8	96.1%
Мөнгөн хөрөнгө	491.5	24.5%
Зээл /цэврээр/	1,222.6	60.9%
Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	11.9	0.6%
Факторингийн тооцооны авлага /цэврээр/	3.0	0.2%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	15.0	0.7%
Бусад хөрөнгө	183.8	9.2%
Эргэлтийн бус хөрөнгө	79.1	3.9%



ББСБ-уудын пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	2,006.9	100.0%
Өр төлбөр	556.2	27.7%
Санхүүгийн эх үүсвэр	146.9	7.3%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	171.2	8.5%
Бусад эх үүсвэр	43.2	2.2%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	62.5	3.1%
Төслийн зээлийн санхүүжилт	20.8	1.0%
Бусад өр төлбөр	111.7	5.6%
Эздийн өмч	1,450.7	72.3%
Хувьцаат капитал	1,017.7	50.7%
Бусад өмч	32.9	1.6%
Сангууд	1.1	0.1%
Хуримтлагдсан ашиг/ алдагдал	398.1	19.8%
Хоёрдогч өглөг	0.8	0.0%




8 ББСБ

75%



172 ББСБ



41 ББСБ

100%



532 ББСБ

Зах зээлд эзлэх хувь хэмжээ буюу нийт хөрөнгөд эзлэх хувиар нь харвал салбарын нийт хөрөнгийн

- 25 хувийг хамгийн их хөрөнгө бүхий 8 ББСБ;
- 50 хувийг хамгийн их хөрөнгө бүхий 41 ББСБ;
- 75 хувийг хамгийн их хөрөнгө бүхий 172 ББСБ эзэлж байна.


	ББСБ-ын тоо		Нийт хөрөнгө		Нийт зээл		Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь	Харилцагчдын тоо	
	Тоо	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Хэмжээ /тэрбум төг/	%		Тоо	%
Топ 25 %	8	1.5%	508.6	25.3%	342.4	25.8%	5.7%	272,383	9.6%
Топ 50 %	41	7.7%	1,004.0	50.0%	697.9	52.6%	8.0%	2,575,480	90.3%
Топ 75 %	172	32.3%	1,504.6	75.0%	1,028.9	77.5%	9.7%	2,729,673	96.1%
НИЙТ	532	100.0%	2,006.9	100.0%	1,327.0	100.0%	10.3%	2,844,782	100.0%

Банк бус санхүүгийн зах зээлийн нийт хөрөнгийн 25, 50 болон 75 хувийг бүрдүүлж буй ББСБ-уудын зээлийн үлдэгдэл салбарын нийт зээлийн үлдэгдлийн 25.8, 52.6, болон 77.5 хувийг тус тус эзэлж байна. Нийт хөрөнгө болон нийт зээлийн үлдэгдлийн эзлэх хувь ойролцоо хэдий ч нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь харгалзан 5.7, 8.0 болон 9.7 хувьтай байна. Өөрөөр хэлбэл салбарт эзлэх хэмжээ их ББСБ-уудын зээлийн чанар салбарын дундажтай харьцуулахад сайн байна.

Салбарын нийт хөрөнгийн 50 хувийг бүрдүүлж буй 41 ББСБ-уудын зарим нь үйл ажиллагаандаа технологийн дэвшлийг ашиглан, хүртээмжтэй байдлаар үйлчилгээг үзүүлдэг тул нийт үйлчлүүлэгчдийн 90.3 хувь нь зөвхөн эдгээр ББСБ-уудын харилцагчид байна.

	ББСБ-ын тоо	Нийт хөрөнгө		Нийт зээл		Харилцагчдын тоо	
		Хэмжээ /тэрбум төг/	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Тоо	%
Дотоодын хөрөнгө оруулалт бүхий	502	1,690.4	84.2%	1,108.1	83.5%	2,780,364	97.7%
Гадаадын хөрөнгө оруулалт бүхий	30	316.5	15.8%	218.9	16.5%	64,418	2.3%

Нийт гадаад хөрөнгө оруулалт бүхий ББСБ-уудын 41.3 хувь буюу 12 нь Япон улсын, 27.6 хувь нь буюу 8 нь БНСУ-ын, 2 нь АНУ-ын, 2 нь Их Британи улсын, үлдсэн нь Малайз, Хонг Конг зэрэг бусад улсын хөрөнгө оруулалттай байна. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьд хэдийгээр салбарын нийт хөрөнгийн 15.8 хувийг эзэмшдэг бөгөөд нийт харилцагчдын 2.3 хувьд үйлчилгээ үзүүлдэг байна.




2020 оны байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгө Монгол Улсын ДНБ-ий 5.4 хувьтай тэнцэхүйц хэмжээнд байна.

Нийт зээл /тэрбум төгрөг/



Зээлийн хүү: 2020 оны байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 2.8 хувьд хүрч өмнөх оноос 0.2 нэгжээр, 2016 оноос 1.2 нэгжээр буурлаа.



НИЙТ ЗЭЭЛ

2020 оны байдлаар салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 7.6 хувиар буюу 93.9 тэрбум төгрөгөөр, 2016 оноос 177.5 хувиар буюу 848.9 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.

2020 оны байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 96.9 хувийг төгрөгөөр олгосон зээл, үлдсэн 3.1 хувийг валютаар олгосон зээл тус тус эзэлж байна.

96.9%



ХЭВИЙН

84.8%

-2.2%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН

4.9%

-0.4%



ЧАНАРГҮЙ

10.3%

+1.7%

1,602.4 тэрбум төгрөг | Олгосон зээл

Төлөгдсөн зээл | 1,518.5 тэрбум төгрөг

Хэрэглээ



62.1%

62.7%

Бөөний болон жижиглэн худалдаа



12.0%

13.2%

Барилга



7.8%

6.5%

Уул, уурхайн олборлолт



1.9%

2.6%

Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйлчилгээ



2.9%

2.4%

Машин, мотоциклийн засвар үйлчилгээ



2.4%

1.8%

Боловсруулах үйлдвэр



1.1%

1.5%

Бусад






9.8%

9.3%

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ


Улсын хэмжээнд тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхэлж буй 532 банк бус санхүүгийн байгууллага нийт 295 салбартай. Банк бус санхүүгийн байгууллагын байршлыг зураглалаар харуулбал дийлэнх нь буюу 85.5 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж байна.






Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ээс санхүүгийн хүртээмжийг тооцоход сонголттой байдлын үзүүлэлт болох дор хаяж 3 санхүүгийн байгууллага бүхий засаг захиргааны нэгжийн хувийг тооцохыг зөвлөсөн байдаг. Нийт 21 аймгийн 52.4 хувь буюу 11 аймагт 3 буюу түүнээс дээш тооны банк бус санхүүгийн байгууллага байна.

1 000 аж ахуйн нэгжид ногдох



100 000 хүн амд ногдох



Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж буй 455 ББСБ-ын 35.2 хувь нь Сүхбаатар дүүрэгт, 28.8 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 16.3 хувь нь Баянгол дүүрэгт, 11.0 хувь нь Баянзүрх дүүрэгт, 7.0 хувь нь Хан-Уул дүүрэгт, 1.5 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 0.2 хувь нь Багануур дүүрэгт тус тус байршилтай байна.

ББСБ-УУДЫН ХҮРТЭЭМЖ, ГАЗАРЗҮЙН БАЙРШЛААР


- Монгол Улсын хэмжээнд 18–64 насны 100,000 иргэнд 26 банк бус санхүүгийн байгууллага, 1000 аж ахуйн нэгжид 26 банк бус санхүүгийн байгууллага ногдож байна.
- Орон нутгийн хэмжээнд уг харьцаанууд нь 10, 5 байгаа бөгөөд бүс нутгийн хувьд Төвийн бүс 100,000 иргэнд 14, 1000 аж ахуй нэгжид 7 банк бус санхүүгийн байгууллага ногдож байгаагаар банк бус санхүүгийн байгууллагын хүртээмжээр тэргүүлж байна.
- Улаанбаатар хотын хувьд 100,000 иргэнд 44, 1000 аж ахуйн нэгжид 10 банк бус санхүүгийн байгууллага ногдож байгаа нь хөдөө орон нутгаас хүртээмж сайтай байгааг харуулж байна




ДУНДАЖ ЗЭЭЛ

- 2020 онд Монгол Улсын хэмжээнд ББСБ-аас нэг зээлдэгч дунджаар 1.7 сая төгрөгийн зээл авсан бол орон нутагт энэхүү үзүүлэлт 1.9 сая төгрөг, Улаанбаатар хотын хувьд 1.7 сая төгрөг байна.
- Харин уг үзүүлэлт өмнөх онд улсын хэмжээнд 2.9 сая төгрөг байсан ба тайлант оны хувьд банк бус санхүүгийн байгууллагаас зээл авсан нэг зээлдэгчид ногдох зээлийн дундаж хэмжээ 57.3 хувиар буюу 1.2 сая төгрөгөөр буурчээ.
- Энэхүү бууралт нь зээлдэгчдийн тооны өсөлттэй холбоотой.
- Нийт зээлдэгчдийн тоо 788.0 мянга байгаа нь давхардсан тоогоор хөдөлмөрийн насны буюу 18–64 насны 100 хүн тутмын 25 нь ББСБ-аас зээлтэй байна гэсэн үг юм.


ББСБ-ын харилцагчид



ББСБ-ын зээлдэгчид /насны бүлгээр/




ББСБ-ын зээлдэгчид /боловсролын түвшингээр/



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ



ББСБ-ЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/



БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО

- 2020 оны байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын нийт орлого 408.8 тэрбум төгрөгт хүрэв.
- Нийт орлогын 97.9 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу хүүгийн болон хүүгийн бус орлого бүрдүүлж байна. Үүнээс нийт орлогын 82.7 хувь буюу 337.9 тэрбум төгрөгийг хүүгийн орлого, 15.2 хувь нь буюу 62.2 тэрбум төгрөгийг хүүгийн бус орлого бүрдүүлж байна.


- Хүүгийн орлого
- Хүүгийн бус орлого
- Үндсэн бус үйл ажиллагааны орлого
- Үндсэн үйл ажиллагааны орлого



- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого
- Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого
- Арилжааны орлого
- Картын үйлчилгээний орлого
- Мөнгөн гуйвуулгын орлого
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого
- Бусад

ХҮҮГИЙН БУС ОРЛОГЫН ЗАДАРГАА

- Хүүгийн бус орлогын 48.5 хувийг үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого, 18.2 хувийг ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого, 15.9 хувийг арилжааны орлого, 2.1 хувийг картын үйлчилгээний орлого, 2.0 хувийг мөнгөн гуйвуулгын орлого, 0.4 хувийг санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого, 12.9 хувийг бусад орлого тус тус бүрдүүлж байна.



- Хүүгийн зардал
- Хүүгийн бус зардал
- Болзошгүй эрсдэлийн зардал
- Үндсэн бус үйл ажиллагааны зардал
- Үндсэн үйл ажиллагааны зардал
- Орлогын албан татварын зардал


БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ

- Нийт зардлын 92.3 хувь нь үндсэн үйл ажиллагааны зардал, 1.7 хувь нь үндсэн бус үйл ажиллагааны зардал, 6.0 хувь нь орлогын албан татварын зардлаас бүрдэж байна.
- Үндсэн үйл ажиллагааны зардлын бүрэлдэхүүн болох хүүгийн зардал нь нийт зардлын 16.8 хувь, хүүгийн бус зардал нь 58.3 хувь, болзошгүй эрсдэлийн зардал 17.2 хувийг бүрдүүлж байна.

Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэлтэй холбоотой гарах зардал буюу болзошгүй эрсдэлийн зардлын хувьд нийт 43.7 тэрбум төгрөг ба үүний 93.1 хувийг зээлийн эрсдэлийн зардал, 4.5 хувийг өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн зардал, 2.4 хувийг авлагын эрсдэлийн зардал бүрдүүлж байна.


- Факторингийн үйлчилгээ гэдэг нь зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүхэлд нь хариуцах үйл ажиллагааг хэлдэг. 2020 оны байдлаар салбарын хэмжээнд нийт 3.0 тэрбум төгрөгийн факторингийн цэвэр авлага бүртгэлтэй байна.

Факторингийн үйлчилгээний цэвэр авлага /тэрбум төгрөг/




- Салбарын хэмжээнд нийт 43 банк бус санхүүгийн байгууллага итгэлцлийн үйлчилгээг эрхэлж байна.
- Тэдгээрийн үзүүлсэн итгэлцлийн үйлчилгээний нийт өглөг 146.9 тэрбум төгрөг байгаа ба өмнөх оноос 35.6 хувиар өслөө.

Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөг/



Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний орлого /тэрбум төгрөг/




- 2020 оны байдлаар банк бус санхүүгийн байгууллагууд мөнгөн гуйвуулгын үйлчилгээнээс нийт 1.5 тэрбум төгрөгийн орлогыг олжээ. Энэ нь өмнөх оноос 517.9 сая төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.
- Салбарын хэмжээнд нийт 34 байгууллага уг үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаагаас тайлант онд 13 нь уг үйлчилгээнээс орлого олсон байна.

ХУДАЛДСАН, ХУДАЛДАН АВСАН ВАЛЮТЫН МЭДЭЭ

2020 онд банк бус санхүүгийн байгууллагууд нийт 1.6 их наяд төгрөгийн валют худалдан авч, 1.5 их наяд төгрөгийн валютыг худалдсан байна. Худалдаж авсан валютын 46.9 хувийг, худалдсан валютын 46.8 хувийг БНХАУ-ын юань бүрдүүлж байна.

ВАЛЮТЫН НЭР	Худалдаж авсан	Худалдсан
	Дүн /тэрбум төгрөг/	Дүн /тэрбум төгрөг/
БНХАУ-ЫН ЮАНЬ	734.5	717.9
АНУ-ЫН ДОЛЛАР	663.5	661.3
ЕВРО	107.8	104.1
БНСУ-ЫН ВОН	18.0	16.7
ЯПОНЫ ИЕН	19.6	14.8
БУСАД	22.9	18.7



Сүүлийн 2 жилийн байдлаар гадаад валют арилжааны дүнгийн графикаас харахад 9 дүгээр сард валют арилжаа хамгийн идэвхтэй явагддаг ба 2 дугаар сард хамгийн идэвх султай байдаг нь харагдаж байна.

ФИНТЕК

15 ББСБ

3 Зөвхөн
технологид
суурилсан

12 Технологи + Уламжлалт

- 2020 онд банк бус санхүүгийн байгууллагуудаас олгосон 1 сар хүртэлх хугацаатай зээлийн 93.5 хувийг гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээгээр дамжуулан олгожээ.

93.5%



- Салбарын нийт харилцагчдын 88.4 хувь нь эдгээр банк бус санхүүгийн байгууллагын харилцагчид буюу технологид суурилсан зээлийн үйлчилгээг хүртэх боломжтой байна.
- Нийт зээлдэгчдийн 40.0 хувь нь зөвхөн гар утсаараа дамжуулан зээл авч байна.

- 2020 оны байдлаар санхүүгийн үйлчилгээнд технологийн дэвшил ашиглаж буй банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн 90.1 хувийг хэвийн зээл, 3.4 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 6.5 хувийг чанаргүй зээлийн үлдэгдлээс тус тус бүрдүүлээ.

88.4%



90.1% Хэвийн


3.4% Хугацаа хэтэрсэн
зээл

6.5% Чанаргүй

Салбарын нийт зээлийн үлдэгдэлд бага хувь эзэлж байгаа ч олгосон болон төлөгдсөн зээлд эзлэх хувиас харахад эдгээр банк бус санхүүгийн байгууллагуудын зээл эргэлт сайтай байгаа нь харагдаж байна.

	ББСБ-ын тоо		Нийт хөрөнгө		Нийт зээл		Зээлдэгчийн тоо		1 зээлдэгчид ногдох дундаж зээлийн хэмжээ /мян. төгрөг/	Харилцагчдын тоо	
	Тоо	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Тоо	%		Тоо	%
Финтек	15	2.8%	303.2	15.1%	77.4	5.8%	315,605	40.0%	245.2	2,515,149	88.4%
Уламжлалт	517	97.2%	1,703.7	84.9%	1249.6	94.2%	472,453	60.0%	5,245.7	329,633	11.6%
НИЙТ	532	100.0%	2,006.9	100.0%	1,327.0	100.0%	788,058	100.0%	1,683.9	2,844,782	100.0%


АШИГТ АЖИЛЛАГАА



	<1%	<5%	<10%	>10%		
Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/	12.5% (2019)	11.4% (2020)	30.5%*	16.9%	14.8%	37.8%
Нийт хөрөнгийн өгөөж /ROA/	9.3%	8.3%	31.2%	17.9%	16.7%	34.2%

ROE болон ROA-ийн харгалзах интервал дахь ББСБ-ын тоо /хувиар/

(*) Жишээ нь: Нийт ББСБ-уудын 30.5 хувь нь 1 хувиас доош өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажиллаж байна



НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙН ХАРЬЦАА /ХӨРӨНГИЙН АНГИЛЛААР/

Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөжийг хувь нийлүүлсэн хөрөнгийн ангиллаар харахад 1 тэрбумаас доош хувь нийлүүлсэн хөрөнгөтэй банк бус санхүүгийн байгууллагуудын тал хувь нь 2.2 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй, 1–2.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй банк бус санхүүгийн байгууллагуудын тал хувь нь 6.5 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй, 2.5 тэрбум төгрөгөөс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй банк бус санхүүгийн байгууллагуудын тал хувь нь 7.3 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй байна. Өөрийн хөрөнгийн өгөөжийн хувьд холбогдох утгууд нь харгалзан 2.2, 6.8 болон 10.9 хувьтай байна.


ЗАРДАЛ, ОРЛОГЫН ХАРЬЦАА

Банк бус санхүүгийн байгууллагууд нэг төгрөгийн орлого олохын тулд дунджаар хэдэн төгрөгийн зардал гаргаж буйг тооцдог харьцаа болох зардал, орлогын харьцаа тайлант онд 46.6 хувь гарсан буюу өмнөх оноос 3.0 нэгжээр өсжээ. Өөрөөр хэлбэл банк бус санхүүгийн байгууллагууд 100 төгрөгийн орлого олохын тулд дунджаар 46.6 төгрөгийн зардал гаргаж байна гэсэн үг юм.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ


- o AFI буюу “Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг”-ээс санхүүгийн хүртээмж болон санхүүгийн тогтвортой байдлын тодорхойлох зөвлөмж зааврын дагуу банк бус санхүүгийн байгууллагуудын дараах 4 үзүүлэлтийг тооцож байна. Үүнд:



ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХАРЬЦАА


- o Тайлант онд уг харьцаа 101.8 хувь гарч байгуулбал зохих эрсдэлийн санг бүрдүүлж чадсан бөгөөд эрсдэлийг 101.8 хувиар нөхөх чадамжтайг харуулжээ.
- o Энэ нь өмнөх оноос 0.5 нэгжээр буурсан үзүүлэлт юм.

101.8%




ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ

Тайлант онд чанаргүй зээлийн хэмжээ 136.4 тэрбум төгрөгт хүрч чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 10.3 хувь болж өслөө. Энэ нь өмнөх оноос 1.8 нэгжээр өссөн байна.




ХӨРВӨХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА

- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа буюу хөрвөх чадвар тайлант онд 24.5 хувь болжээ.
- 2020 онд мөнгөн хөрөнгийн өсөлт 35.0 хувьтай байгаа нь нийт хөрөнгийн өсөлтөөс 19.0 пунктээр их байгаа тул хөрвөх чадвар өмнөх оноос 3.5 пунктээр өссөн байна.



Z ИНДЕКС

Z индекс нь банк бус санхүүгийн байгууллагын дампуурах магадлалыг харуулдаг ба активын өгөөж болон өөрийн хөрөнгийн харьцааны нийлбэрийг активын өгөөжийн хэлбэлзэлд харьцуулж тооцдог. Z индексийн утга ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хөшүүрэг өндөр байх үед их гарах ба өгөөжийн хэлбэлзэл ихтэй үед буюу орлогын тодорхойгүй байдал их үед бага гарна. Өөрөөр хэлбэл индексийн их утга нь эрсдэл багатай, тогтвортой байдлыг илэрхийлдэг. 2020 оны байдлаар банк бус санхүүгийн салбарын Z индекс өмнөх оноос 4.8 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Хорооны зохицуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын мэргэжлийн холбоод болон сургалтын байгууллагуудтай хамтран ажиллаж Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж байгаа төслийн зөвлөхтэй уулзалт зохион байгуулж, салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалт, ББСБ-уудыг чадавхжуулах чиглэлээр сургалт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.
- Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн “Хүртээмжтэй ногоон санхүүжилт” ажлын хэсэгт ажиллаж байна. Ажлын хэсгийн семинар хуралд оролцож, “Covid-19 цар тахлын үед байгаль орчин, ногоон эдийн засгийг хөгжүүлэх” сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон. Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгээс банк бус санхүүгийн байгууллагын салбарт ногоон санхүүжилтийн төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ээс хэрэгжүүлж буй “Зохицуулалттай этгээдүүдийн ногоон санхүү эрхлэх чадавх” төслийн хүрээнд ББСБ-уудад мэдээлэл хүргүүлж “Ногоон санхүү” судалгааг 266 ББСБ-аас авсан бөгөөд “Зохицуулалттай этгээдүүдийн ногоон санхүү” сэдэвт сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан.
- ОУСК-тай “Ногоон санхүүжилтийг хөгжүүлэх” болон “Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн төслийг хамтран хэрэгжүүлэх” харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус байгуулсан.





ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- ОУСК болон Олон Улсын Факторингийн Холбоотой хамтран “Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт болон факторингийн үйл ажиллагааг хөгжүүлэх нь” сэдэвт ББСБ-уудад зориулсан сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд хамтран зохион байгуулж 70 ББСБ-ын төлөөлөл, арилжааны банкны 10 төлөөлөл, СЗХ-ноос 12 албан хаагчийг хамруулсан.
- НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс болон Монгол Улсын Гадаад харилцааны яам хамтран зохион байгуулсан “Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр ба Монгол улс” сэдэвт семинарт оролцсон.
- Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн “Хүртээмжтэй ногоон санхүүжилт” ажлын хэсэгт ажиллаж, онлайн хурал, гишүүдэд зориулсан онлайн семинарт тухай бүр оролцож байна.
- СЗХ нь Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран банк бус санхүүгийн байгууллагуудын удирдах албан тушаалтныг сертификатжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулж, сургагч багшаар ажиллав.
- Монголбанк, СЗХ, ОУСК, Тогтвортой санхүүгийн холбооноос хамтран зохион байгуулсан “Тогтвортой санхүүжилт дэх санхүүгийн зохицуулагч байгууллагуудын оролцоо, бодлогын дэмжлэг” сэдэвт онлайн семинарт хамрагдсан.
- UNEP FI, Голомт Банк, Тогтвортой санхүүгийн холбооноос хамтран зохион байгуулсан “Хариуцлагатай банкны зарчмууд ба уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ” сэдэвт онлайн семинарт хамрагдсан.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам” батлах тухай тогтоолыг 2020 оны 01 дугаар сарын 15–ны өдрийн СЗХ–ны хуралдаанаар хэлэлцүүлэн, 10 дугаар тогтоолоор батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4672 дугаараар бүртгүүлсэн.
- СЗХ–ны 2020 оны 6 дугаар сарын 10–ны өдрийн 352 дугаар тогтоолоор “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”–д өөрчлөлт оруулсан. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 127 дугаараар бүртгүүлсэн.
- СЗХ–ны 2020 оны 6 дугаар сарын 29–ний өдрийн 495 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагын гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам”–д өөрчлөлт оруулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4835 дугаараар бүртгүүлсэн. Гадаад валютын арилжааг нэгдсэн бодлогоор зохицуулах, хяналт тавих, үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд бизнесийн таатай нөхцөлийг бүрдүүлэх, програм хангамжийг сайжруулах, харилцагчийг таньж мэдэх, нөгөө талаас төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах, арилжаа хийж буй харилцагчийн мэдээлэл, арилжааны дүн мэдээг бүрэн авах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тус журмыг боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.
- СЗХ–ны 2020 оны 12 дугаар сарын 09–ний өдрийн 998 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”–ыг шинэчлэн баталсан. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4925 дугаараар бүртгүүлсэн.
- СЗХ–ны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13–ны өдрийн 144/125 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”–д 2020 оны 3 дугаар сарын 18–ны өдрийн 122/58 тоот хамтарсан тушаалаар өөрчлөлт оруулж, 2020 оны 01 дүгээр сарын 31–ний өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 31–ний өдрийг хүртэлх түр хугацаанд хэрэгжүүлж ажиллахаар шийдвэр гаргасан.
- Энэ журамд өөрчлөлт оруулсан хүчинтэй хугацаа 2020 оны 7 дугаар сарын 31–ний өдөр дуусгавар болсон тул СЗХ–ны 2020 оны 8 дугаар сарын 26–ны өдрийн “Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоодод авах арга хэмжээний тухай” 854 дүгээр тогтоолоор баталсан ба энэхүү тогтоолоор хугацаа хэтэрсэн, хэвийн бус, эргэлзээтэй, муу зээлийн ангилалд оруулах хугацааг 122/58 тоот тушаалаар баталсан хуваарьт өдрүүдээс хугацааг богиносгож, дараах байдлаар тооцохоор шийдвэрлэсэн. 854 дүгээр тогтоолоор зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлт нь хугацаандаа хийгдэж байгаа бол хэвийн зээлд тооцохоор байсныг 90 хоногоор хугацаа хэтэрсэн бол хэвийн зээлд тооцохоор, хугацаа хэтэрсэн зээлийн ангилалд 1–90 хүртэл хоног байсныг 91–150 хоног, чанаргүй зээлийн ангилалд 151 хоногоос дээш хугацаанд хугацаа хэтэрсэн тохиолдолд бүртгэж байхаар зохицуулсан. Энэхүү тогтоолыг 2020 оны 12 дугаар сарын 31–ний өдрийг дуустал хэрэгжүүлж ажиллахаар шийдвэрлэсэн. Тогтоолын хэрэгжих хугацааг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолыг үндэслэн сунгаж 2021 оны 7 дугаар сарын 01–ний өдөр хүртэл мөрдөж ажиллахыг СЗХ–ны 2020 оны 12 дугаар сарын 23–ны өдрийн 1020 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн.
- 2020 оны 3 дугаар сарын 25–ны өдрийн 148 дугаар тогтоолоор үүсээд байгаа эдийн засгийн хүндрэлтэй байдлын үед банк бус санхүүгийн байгууллагуудын төлбөрийн чадварт дэмжлэг үзүүлж банк бус санхүүгийн байгууллагуудын улсын төсөвт жил бүрийн 4 дүгээр сарын 01–ний өдрийн дотор төвлөрүүлдэг зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх хугацааг 2020 оны 7 дугаар сарын 31–ний өдөр болгон хойшлуулах шийдвэрийг гаргасан байна. Ингэснээр харилцагч, зээлдэгчдийнхээ өрийн дарамтыг багасгах боломжийг олгож байгаа юм.





ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Нийт хөрөнгө

256.0 тэрбум төгрөг

Хөрөнгийн өсөлт **15.0%**



Санхүүгийн зах зээлийн төлөв

Нийт салбар **61**

Нийт гишүүдийн

42.5%

дээд боловсролтой



Хүртээмжтэй байдал

Хэрэглээ болон түүнтэй
холбогдох бусад зориулалтаар
олгогдсон зээл

85.0%



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Цэвэр ашиг

9.2

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Нийт зээлд эзлэх чанаргүй
зээлийн хувь

4.4%


Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

ХЗХ–ДЫН ТОО БА ГИШҮҮД

- 2020 оны байдлаар тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй ХЗХ–дын тоо 249–д хүрч өмнөх оноос 4.6 хувиар буурлаа.
- ХЗХ–дын гишүүдийн тоо 2019 онд 70,968 байсан бол тайлант онд 2.4 хувиар өсөж 72,651 гишүүн болжээ.
- Тайлант оныг 2016 онтой харьцуулахад ХЗХ–ны нийт тоо 31–ээр буюу 11.1 хувиар буурсан бол ХЗХ–ны нийт гишүүдийн тоо 26,468–аар буюу 57.3 хувиар буурсан байна.



АЖИЛЛАГСАД

841

ХЗХ–дын нийт ажилтнуудын тоо 841 хүрч өнгөрсөн оноос 3.7 хувиар өссөн бөгөөд түүний 70.9 хувь нь эмэгтэй ажиллагсад байна.

НИЙТ ГИШҮҮДИЙН


35,827

ЗЭЭЛДЭГЧ

35,870

ХАДГАЛАМЖ
ЭЗЭМШИГЧ

■ Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/ ○ Нийт хөрөнгийн өсөлт /хувь/



НИЙТ ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨСӨЛТ

- Тайлант онд нийт хөрөнгө өмнөх оноос 15.0 хувиар өсөж 256.0 тэрбум төгрөгт хүрлээ.
- Хөрөнгийн өсөлтийн хувь /инерц/ өмнөх оноос 3.8 пунктээр өссөн.
- Тайлант оныг 2016 онтой харьцуулахад ХЗХ–ны нийт хөрөнгийн дүн 142.8 тэрбум төгрөгөөр буюу 126.3 хувиар нэмэгдсэн байна.

НИЙТ ЗЭЭЛ

167.6

ТЭРБУМ ТӨГРӨГ

НИЙТ ХАДГАЛАМЖ

182.2

ТЭРБУМ ТӨГРӨГ

НИЙТ ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

- 85.5 хувийг 1 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 22 ХЗХ;
- 4.9 хувийг 500 саяас 1 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй 17 ХЗХ;
- 9.6 хувийг 500 сая төгрөгөөс доош хөрөнгөтэй 210 ХЗХ эзэлж байна.

85.5%

22 ХЗХ

4.9%
17 ХЗХ9.6%
210 ХЗХ


ХЗХ-дын актив болон пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

Нийт хөрөнгийн дүн	255.9	100%
Эргэлтийн хөрөнгө	251.6	98.3%
Мөнгөн хөрөнгө	77.7	30.3%
Зээл /цэврээр/	162.6	63.5%
Авлага	9.4	3.7%
Бусад эргэлтийн хөрөнгө	0.9	0.3%
Өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	1.0	0.4%
Эргэлтийн бус хөрөнгө	4.4	1.7%
Үндсэн хөрөнгө /цэврээр/	4.2	1.6%
Биет бус хөрөнгө /цэврээр/	0.2	0.1%
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	255.9	100%
Өр төлбөр	206.5	80.7%
Хадгаламж	182.2	71.2%
Богино хугацаат зээл	3.0	1.2%
Бусад богино хугацаат өр төлбөр	15.4	6.0%
Урт хугацаат өр төлбөр	5.9	2.3%
Өөрийн хөрөнгө	49.5	19.3%
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	18.5	7.2%
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.3	0.1%
Хоршоологчдын өмч	30.7	12.0%



- Нийт хөрөнгийн 98.2 хувь нь эргэлтийн хөрөнгө, 1.8 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байна.
- Нийт хөрөнгийн 22.6 хувийг мөнгөн хөрөнгө, 71.0 хувийг зээлийн цэвэр үлдэгдэл, 3.8 хувийг авлагын үлдэгдэл бүрдүүлж байна.
- Эх үүсвэрийн хувьд нийт хөрөнгийн 79.7 хувийг өр төлбөр, 20.3 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ



БАРУУН БҮС

45 ХЗХ

8 САЛБАР

ХАНГАЙН БҮС

24 ХЗХ

15 САЛБАР

ТӨВИЙН БҮС

22 ХЗХ


19 САЛБАР

ЗҮҮН БҮС

10 ХЗХ

12 САЛБАР

- Тайлант онд нийт 249 ХЗХ-ноос 148 ХЗХ нь нийслэл Улаанбаатар хотод, 101 ХЗХ нь хөдөө, орон нутагт бүртгэлтэй байна.
- Хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын 44.5 хувь нь баруун бүсэд, 9.9 хувь нь зүүн бүсэд, 23.8 хувь нь хангайн бүсэд, 21.8 хувь нь төвийн бүсэд байршжээ.
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 148 ХЗХ-ны 92.6 хувь нь төвийн зургаан дүүрэгт, 7.4 хувь нь алслагдмал гурван дүүрэгт байршиж байна.




“Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)”-ийн Санхүүгийн хүртээмжийн тоон мэдээллийн ажлын хэсгээс улс орнуудын санхүүгийн хүртээмжийг үнэлэх үндсэн индикаторуудыг¹ 2013 онд гаргасан. Тус индикаторуудыг ашиглан салбарын хүртээмжтэй байдлыг харуулъя. Үүнийг хөдөлмөрийн насны буюу 18–64 насны 10,000 хүнд ногдох, 1,000 аж ахуйн нэгж (ААН)-д ногдох ХЗХ-дын тоогоор илэрхийлж болно.

10 000 хүнд ногдох ХЗХ-ны тоо



1 000 ААН-д ногдох ХЗХ-ны тоо



- 1,000 ААН-д ногдох ХЗХ-ны тоогоор Багануур дүүрэг 6.2, Налайх дүүрэг 6.1, Чингэлтэй дүүрэг 1.7 үзүүлэлттэйгээр тус тус тэргүүлж байгаа бол Баянгол дүүрэг 0.4 гэсэн үзүүлэлттэйгээр хамгийн доогуур жагсаж байна.
- Харин 10,000 хүнд ногдох ХЗХ-ны тоогоор Багахангай, Налайх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүд тус тус 3.8, 3.4, 3.3, 3.0 гэсэн үзүүлэлтээр тэргүүлж байна.

¹ <https://www.afi-global.org/sites/default/files/publications/fidwg-core-set-measuring-fi.pdf>



Хүртээмжийн үзүүлэлтийг 4 бүсээр ангилахад баруун бүс 10,000 хүнд ногдох, 1,000 ААН-д ногдох ХЗХ-дын тоогоор бусад бүсээс илүү сайн үзүүлэлттэй байна.

Нэг гишүүнд ногдож буй дундаж зээл




ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–64 насны 57 хүн тутмын нэг нь ХЗХ-нд гишүүнчлэлтэй, зээлийн үйлчилгээг хүртэж байна.
- Дээрх үзүүлэлт нь хөдөө, орон нутагт 76 хүн тутмын нэг байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд 44 хүнд нэг тохиож байна.
- Улсын хэмжээнд ХЗХ-ноос зээл авсан нэг зээлдэгч гишүүн дунджаар 4.7 сая төгрөгийн зээлтэй байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 6.5 сая төгрөг байгаа бол хөдөө, орон нутагт 2.1 сая төгрөг байна.

ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–64 насны 57 хүн тутмын нэг нь ХЗХ-нд гишүүнчлэлтэй, хадгаламжийн үйлчилгээг хүртэж байна.
- Дээрх үзүүлэлт хөдөө, орон нутагт 69 хүнд нэг байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд 47 хүнд нэг тохиож байна.
- Улсын хэмжээнд ХЗХ-нд хадгаламжтай нэг хадгаламж эзэмшигч гишүүн дунджаар 5.1 сая төгрөгийн хадгаламжтай байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 7.8 сая төгрөг байгаа бол хөдөө, орон нутагт 1.6 сая төгрөг байна.

Нэг гишүүнд ногдож буй хадгаламжийн дундаж хэмжээ



ХЗХ-НЫ ГИШҮҮДИЙН ХҮРТЭЭМЖ

Эрэгтэй



53.7%

Эмэгтэй



46.0%

Хуулийн этгээд



0.3%

НАСНЫ БҮЛГЭЭР

18-35 НАС



29.3%

36-45 НАС



30.3%

46-55 НАС



23.8%

55-ААС ДЭЭШ



16.6%

БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР



42.4%

ДЭЭД



14.1%

ТУСГАЙ
ДУНД



30.7%

БҮРЭН
ДУНД



9.8%

ДУНД




3.0%

БАГА

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ХЗХ–ДЫН ЗЭЭЛ

- Тайлант онд нийт зээлийн хэмжээ 167.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 6.9 хувиар өслөө.
- Цэвэр зээлийн хэмжээ өмнөх оноос 6.8 хувиар өсөж 162.6 тэрбум төгрөгт, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 11.4 хувиар өсөж 5.0 тэрбум төгрөгт хүрлээ.
- Тайлант оныг 2016 онтой харьцуулахад ХЗХ–ны нийт зээлийн үлдэгдлийн дүн 83.1 тэрбум төгрөгөөр буюу 98.4 хувиар нэмэгдсэн байна.



ХЭВИЙН

92.3%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН

3.3%



ЧАНАРГҮЙ

4.4%

ХЗХ–ДЫН ЗЭЭЛИЙН ЧАНАР

- Тайлант онд хэвийн зээлийн хэмжээ өмнөх оноос 8.0 хувиар өсөж 154.7 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт зээлийн 92.3 хувийг хэвийн зээл эзэлж байна.
- Хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өмнөх оноос 23.9 хувиар буурч 5.5 тэрбум төгрөгт хүрлээ.
- Чанаргүй зээлийн хэмжээ 19.7 хувиар өсөж 7.4 тэрбум төгрөгт хүрлээ.
- Тайлант оныг 2016 онтой харьцуулахад ХЗХ–ны салбарын нийт чанаргүй зээлийн дүн 2.8 тэрбум төгрөгөөр буюу 62 хувиар нэмэгдсэн байна.

ХЗХ–ДЫН ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ


- Нийт олгосон зээлийн 84.3 хувь нь хэрэглээ болон түүнд холбогдох бусад зориулалтаар, 5.6 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 2.7 хувь нь хөдөө аж ахуйн салбарт олгогдсон байна.
- Нийт эргэн төлөгдсөн зээлийн 85.0 хувь нь хэрэглээ болон түүнд холбогдох бусад зориулалтаар зээлээс, 5.5 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдааны үйл ажиллагаанаас, 2.6 хувь нь хөдөө аж ахуйн салбараас эргэн төлөгдсөн байна.

ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ

ОЛГОСОН ЗЭЭЛ



■ Нийт хадгаламж /тэрбум төгрөг/ ○ Хадгаламжийн өсөлт /хувь/



ХЗХ-ДЫН ХАДГАЛАМЖ

- ХЗХ-дын нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оноос 16.9 хувиар өсөж 182.2 тэрбум төгрөг боллоо.
- Тайлант оныг 2016 онтой харьцуулахад ХЗХ-ны нийт хадгаламжийн хэмжээ 114.7 тэрбум төгрөгөөр буюу 169.9 хувиар нэмэгдсэн байна..

НИЙТ ХАДГАЛАМЖ

- 98.3 хувийг хугацаатай хадгаламж, 1.7 хувийг хугацаагүй хадгаламж бүрдүүлж байна.



98.3%

ХУГАЦААТАЙ




1.7%

ХУГАЦААГҮЙ



- Тайлант онд ХЗХ-дын 94.8 хувь буюу 236 ХЗХ нь нийт 182.2 тэрбум төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн.
- Үлдсэн 5.2 хувь буюу 13 ХЗХ нь хадгаламж татаагүй байна.



НИЙТ ХАДГАЛАМЖИД ЭЗЛЭХ ХУВЬ

- 1 тэрбумаас дээш төгрөгийн хадгаламжтай 19 ХЗХ нь нийт 162.0 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 88.9 хувийг;
- 10 саяас 1 тэрбум төгрөгийн хадгаламжтай 165 ХЗХ нь нийт 19.9 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 10.9 хувийг;
- 10 саяас доош төгрөгийн хадгаламжтай 65 ХЗХ нь нийт 0.3 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 0.1 хувийг тус тус бүрдүүлж байна.



1.5%

Хадгаламжийн жигнэсэн
дундаж сарын хүү

3.0%

Зээлийн жигнэсэн
дундаж сарын хүү

	2019.II	2019.III	2019.IV	2020.I	2020.II	2020.III	2020.IV
ЭЖДХ	3.4	3.12	3.4	3.1	2.9	2.9	3.0
ХЖДХ	1.5	1.45	1.55	1.5	1.5	1.5	1.5

БУСАД ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БҮЙ ХЗХ

2019

2020

Төслийн санхүүжилтийн үйлчилгээ, төсөл хөтөлбөрийг
дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй

104

90

Санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй

3

3

Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөлтэй

3

4

Салбарын зөвшөөрөлтэй

САЛБАР-54

САЛБАР-61

ОРЛОГО

- ХЗХ–дын нийт хүүгийн орлого өнгөрсөн оной харьцуулахад 4.3 хувиар өсөж 50.5 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт хүүгийн орлогын 96.6 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байна.
- Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого 3.2 хувийг, зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого 0.5 хувийг тус тус эзэлжээ.
- Санхүүгийн түрээсийн орлого 17.0 сая төгрөг байна.



ЗАРДАЛ


- ХЗХ–дын нийт хүүгийн зардал өнгөрсөн онтой харьцуулахад 8.4 хувиар өсөж 29.3 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт хүүгийн зардлын 98.4 хувийг хадгаламжийн хүүгийн зардал эзэлж байна.
- Хүүгийн зардлын 1.5 хувийг эзэлж буй банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүү өмнөх оноос 78.7 хувиар өсөж 443.1 сая төгрөг болжээ.
- Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал гараагүй байна.




АШИГТ АЖИЛЛАГАА

ХЗХ-ДЫН ОРЛОГО, ЗАРДАЛ

- Тайлант онд нийт ХЗХ 53.1 тэрбум төгрөгийн орлого, 43.9 тэрбум төгрөгийн зардал, 9.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан.
- Цэвэр ашгийн нийт орлогод эзлэх хувь өмнөх оноос 0.8 пунктээр буурч 17.3 хувьд хүрчээ.



■ Нийт хөрөнгийн өгөөж ■ Өөрийн хөрөнгийн өгөөж




НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ

- ХЗХ-дын өөрийн хөрөнгийн өгөөж нь өмнөх онтой харьцуулахад 2.9 пунктээр буурч 18.5 хувьд хүрлээ.
- Нийт хөрөнгийн өгөөж нь 0.5 пунктээр буурч 3.6 хувьд хүрчээ.

ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД

- Тайлант онд хүүгийн орлогын нийт зээлд эзлэх хувь өмнөх оноос 0.8 пунктээр буурч 30.1 хувьд хүрлээ.
- Тайлант онд ойролцоогоор 100 төгрөгийн бүрийн зээлийн үйлчилгээнээс 30.1 төгрөгийн хүүгийн орлого олсон байна.
- Цэвэр ашгийн нийт орлогод харьцуулан тооцдог цэвэр ахиуц ашгийн харьцаа нь өмнөх оноос 0.8 пунктээр буурч 17.3 хувь болжээ.



ЗАРДАЛ ОРЛОГЫН ХАРЬЦАА


- ХЗХ-дын 100 төгрөгийн орлого тутмын 83 төгрөг нь зардалд ногдож байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ХЗХ нь өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг дараах үндсэн 4 үзүүлэлт /PEARS аргачлал/-ийн дагуу тооцож, мөрдлөг болгон ажилладаг. Үүнд:

1. Хөрөнгийн чанарын болон хамгаалалтын үзүүлэлт;
2. Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт;
3. Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлт;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт.

■ Чанаргүй зээл /тэрбум төгрөг/ ○ Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь




ХЗХ-ДЫН ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

- Нийт чанаргүй зээлийн дүн өнгөрсөн оноос 1.2 тэрбум төгрөгөөр өсөж 7.4 тэрбум төгрөг боллоо.
- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оноос 0.5 пунктээр өсөж 4.4 хувьд хүрлээ. ХЗХ-дын мөрдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр энэхүү үзүүлэлт 5 хувиас бага байх ёстой.

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН АНГИЛАЛ


- Чанаргүй зээлийн ангилал дахь хэвийн бус зээлийн эзлэх хувь өнгөрсөн оноос 8.3 пунктээр өсөж 34.6 хувь болжээ.
- Эргэлзээтэй зээлийн хувьд өнгөрсөн оноос 5.0 пунктээр буурч 20.9 хувьд хүрсэн бол муу зээлийн нийт чанаргүй зээлд эзлэх жин 44.5 хувь байна.

■ Хэвийн бус зээл ■ Эргэлзээтэй зээл ■ Муу зээл




ХЗХ–ДЫН ХӨРВӨХ ЧАДВАР:

- ХЗХ–дын нийт мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа тайлант онд 30.3 хувьтай байна.
- Богино хугацаат хөрөнгө оруулалт болон нийт зээлийн нийлбэрийг нийт хөрөнгөд харьцуулсан үзүүлэлт 65.5 хувьтай байна.



- Зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь
- Зээлийн эрсдэлийн сангийн нийт хөрөнгөд эзлэх хувь



ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САН

- Тайлант онд ХЗХ–дын зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь 3.0 хувь; харин нийт хөрөнгөд эзлэх хувь өмнөх онтой адил 2.0 хувь байна.

Харьцаа	Зохистой хувь	Тайлант онд
Бусдаас авсан зээл/Нийт зээл	<20%	5.34%
Нийт хадгаламж/Нийт хөрөнгө	20%–80%	71.17%
Цэвэр зээл/Нийт хөрөнгө	60%–85%	63.51%
Хоршоологчдын өмч/Нийт хөрөнгө	>5%	12.01%
Нөөцийн сан/Хоршоологчдын өмч	>10%	26.50%
Хадгаламж хамгааллын сан/Хоршоологчдын өмч	>5%	6.22%
Тогтворжилтын сан/Хоршоологчдын өмч	>5%	6.21%
Үйл ажиллагааны зардал/Нийт хөрөнгө	<15%	4.51%

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Монгол Улс гамшгаас хамгаалах өндөржүүлсэн байдлын зэрэгт шилжсэнээс эдийн засгийн идэвхжил саарч, иргэд, аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэний улмаас санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хадгалах зорилгоор СЗХ–ны дарга, Сангийн сайдын 2020 оны 122/58 дугаар тушаалаар “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”–д нэмэлт оруулж, өөрчлөлтийг 2020 оны 7 дугаар сарын 31–ний өдөр хүртэл хугацаанд мөрдүүлэхээр шийдвэрлэсэн. Түр журмын хугацааг Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаанд буюу 2020 оны 12 дугаар сарын 31–ний өдөр хүртэл сунгахаар СЗХ–ны 2020 оны 854 дүгээр тогтоолоор шийдвэрлэж, улмаар 2021 оны 7 дугаар сарын 01–ний өдрийг хүртэл сунгахаар 2020 оны 12 дугаар сарын 23–ны өдрийн 1023 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн.
- СЗХ–ны 2018 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”–д 2020 оны 12 дугаар сарын 23–ны өдрийн 1022 дугаар тушаалаар өөрчлөлт оруулсан.
- Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран ажиллаж улсын бүртгэлд бүртгүүлсэн боловч тусгай зөвшөөрөл авахаар хандаагүй, хандсан боловч нөхцөл шаардлага хангаагүйн улмаас тусгай зөвшөөрөл олгоогүй, эсхүл тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон 285 хадгаламж, зээлийн хоршооны бүртгэлийг хүчингүй болгосон.
- СЗХ–ны 2020 оны 12 дугаар сарын 23–ны өдрийн хуралдаанаар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, хадгаламж, зээлийн хоршооны салбар байгуулах болон санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн хүсэлтийг 2021 оны 7 дугаар сарын 01–ний өдрийг хүртэл хүлээж авахгүй байхаар шийдвэрлэж, тогтоосон хугацаанд гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулах, тогтворжилтын сангийн үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг урт хугацаанд салбарын тогтвортой хөгжлийг хангах ажилд бэлтгэх, хадгаламж, зээлийн хоршоодын эрсдэлийг тогтоох, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.
- УИХ–ын Эдийн засгийн байнгын хорооны 2020 оны 10 дугаар сарын 27–ны өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулсан Хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/–ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна.



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй “Бичил санхүүгийн зах зээлийг чадваржуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”–ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Ажлын албаны даргын 2020 оны 12 дугаар сарын 01–ний өдрийн А/99 дугаар тушаалаар Сангийн яамны төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн уулзалтыг 2020 оны 12 дугаар сарын 17–ны өдөр АХБ–ны бүсийн менежер, төслийн олон улсын болон үндэсний зөвлөхүүдтэй хамтран цахимаар зохион байгуулж хийсэн ажлын талаар танилцуулж, 2021 онд хийх ажлын төлөвлөгөөний талаар хэлэлцсэн.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр Үндэсний эрсдэлийн үнэлгээний хадгаламж, зээлийн хоршооны салбарын эмзэг байдлын үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу боловсруулж, хэлэлцүүлгийг 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан.
- Бичил санхүүгийн бодлогын зөвлөлийн хурлыг 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хуралдуулж, гишүүдэд цаг үеийн байдлын талаар мэдээлэл хийв.
- СЗХ-ноос Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгтэй хамтран банкнаас бусад санхүүгийн салбарын байгууллагуудад “Ногоон санхүүжилт” семинарыг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг хангасан. Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоолоор нийтийг хамарсан хурал, цуглаан, сургалтыг цуцалсан тул тодорхой бус хугацаагаар хойшлогдоод байна.



ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨМЖ

WOCSSU /Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо/-ийн зүгээс ХЗХ-дын Ковид-19 цар тахлын эсрэг хэрэгжүүлэх хариу арга хэмжээний зөвлөгөөг боловсруулсан бөгөөд дараах 9 арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвлөсөн байна. Үүнд:

1. Уян хатан байдлаар зохицуулалт хийх
2. Зайлшгүй шаардлагатай асуудлуудыг тодорхойлох
3. Хөрөнгийн шаардлага, стандартыг тодруулах
4. Нягтлан бодох бүртгэлийн стандартыг тодорхойлох
5. Мэдээллийн технологийн асуудлыг тодорхойлох
6. Тусламж хэрэгтэй байгаа гишүүддээ дэмжлэг үзүүлэх
7. Хөрвөх чадварыг хамгаалах
8. Тайлан гаргахад тавигдах шаардлагыг тодорхойлох
9. Зохицуулалтыг хөнгөвчлөх



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Нийт хөрөнгө

147.1
тэрбум төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Нэг батлан даалтын
дундаж хэмжээ

196.2
сая төгрөг



Хүртээмжтэй байдал

Ирүүлсэн
хүсэлтийн тоо

128

Зөвшөөрөгдсөн
хүсэлтийн тоо

72



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт орлого

8.3 тэрбум төгрөг

Нийт ашиг

4.2 тэрбум төгрөг

Тогтвортой байдал




Чанаргүй батлан
даалтын эзлэх хувь

18.0%



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ




2020 оны байдлаар Сангийн нийт хөрөнгийн хэмжээ 147.1 тэрбум төгрөг хүрч өмнөх оноос 39.4 хувиар буюу 41.6 тэрбум төгрөгөөр өслөө.




- Сангийн батлан даалтын үлдэгдэл 2020 оны байдлаар 66.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 4.5 хувиар буюу 2.9 тэрбум төгрөгөөр өслөө.
- Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл өмнөх оноос 4.7 хувиар буюу 5.7 тэрбум төгрөгөөр өсөж 127.0 тэрбум төгрөгт хүрлээ.





ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ



НИЙТ БАТЛАН ДААЛТЫН ХЭМЖЭЭ





БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

	Батлан даалт гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	Зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо	Эзлэх хувь
2017	107	62	57.9%
2018	356	162	45.5%
2019	193	113	58.5%
2020	128	72	56.3%


2020 оны байдлаар батлан даалт гаргуулах нийт 128 хүсэлт ирснээс 72 хүсэлт нь зөвшөөрөгдсөн байна. Ирүүлсэн хүсэлтийн тоо нь өмнөх оноос 33.7 хувиар, зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо 36.3 хувиар бага байна.



Өмнөх онд үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт батлан даалт түлхүү гаргаж байсан бол тайлант онд бөөний болон жижиглэн худалдааны салбарт гаргасан батлан даалт нийт батлан даалтын дийлэнх хэсгийг бүрдүүлж байна. 2020 оны байдлаар хөдөө аж ахуй, үйлчилгээ, үйлдвэрлэлийн салбарт гаргасан батлан даалтын нийт батлан даалтад эзлэх хувь буурсан байна.

- 2016 оны сүүл үеэс эхлэн батлан даалт гаргах дундаж хугацаа өссөн дүнтэй байна
- 2020 онд гаргасан батлан даалтын дундаж хугацаа 88.5 сар буюу 7.4 жил байна.

88.5
SAR



Банкны ангиллаар

- Төрийн банк 38.6%
- Капитрон банк 20.8%
- Худалдаа хөгжлийн банк 26.8%
- Хаан банк 13.3%
- Хас банк 0.5%

2020 онд Сангаас гаргасан батлан даалтын 38.6 хувийг Төрийн банк, 26.8 хувийг Худалдаа хөгжлийн банк, 20.8 хувийг Капитрон банк, 13.3 хувийг Хаан банк, 0.5 хувийг Хас банкны зээлд гаргасан батлан даалт тус тус бүрдүүлж байна.

АШИГТ АЖИЛЛАГАА




Орлогын бүтэц



Зардлын бүтэц



Нийт хөрөнгийн өгөөж





2020 оны байдлаар сангийн нийт хөрөнгийн өгөөж 3.3 хувь байгаа нь өмнөх оноос 0.9 нэгжээр өссөн дүн юм.

Сангийн хөрөнгийн нэгж тутамд ногдож буй цэвэр ашгийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 0.9 нэгжээр өссөн гэсэн үг юм.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

2020 оны байдлаар чанаргүй батлан даалтын үлдэгдэл 11.9 тэрбум төгрөгт хүрлээ.

Чанаргүй батлан даалтын үлдэгдэл /тэрбум төгрөг/



Батлан даалтын нийт үлдэгдэлд эзлэх чанаргүй батлан даалтын хувь 18.0 болж өмнөх оноос 4.7 пунктээр өслөө.

- Чанаргүй батлан даалтын үлдэгдлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 42.8 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 31.3 хувь нь үйлчилгээний салбарт, 14.3 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 11.6 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон батлан даалтууд бүрдүүлж байна.
- Жил ирэх тусам үйлдвэрлэлийн болон хөдөө аж ахуйн салбарын чанаргүй батлан даалтын эзлэх хувь багасаж байгаа бол болон үйлчилгээний салбарын чанаргүй батлан даалт өссөн байна.



Үйлдвэрлэл




Хөдөө аж ахуй



Бөөний болон жижиглэн худалдаа



Үйлчилгээ





ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР

Зохицуулалттай этгээд

167



Салбарын төлөв

281.9 тэрбум
төгрөгийн үнэ бүхий
ҮХХ-ийг зуучлан
худалдан, худалдан
авч, шилжүүлжээ



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Цэвэр ашиг

0.17

тэрбум төгрөг



Ашигт ажиллагаа

Хүртээмжтэй байдал



98.2%

Улаанбаатар хотод үйл
ажиллагаа эрхэлж байна

Бодлого зохицуулалт



САЛБАРЫН ТӨЛӨВ



Хорооны тусгай
зөвшөөрөлтэй

167

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн хүрээнд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь СЗХ-ны зохицуулалтад тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхлэхээр хуульчлагдсан.

СЗХ-ны 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар анхны ҮХЭХЗ-ын байгууллагад тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд 2020 оны байдлаар нийт 167 ҮХЭХЗ-ын байгууллага тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна. Энэ нь 3 дугаар улирлын дүнгээс 19.3 хувиар өссөн үзүүлэлт юм.

Тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗ-ын
байгууллагууд:

Брокер
188



Агент
1,171



Нэг ҮХЭХЗ-ын байгууллага дунджаар
1 брокер, 7 агенттай ажиллаж байна.
Хамгийн олон агентын тоо 106 байна.



ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗ-ын байгууллагуудын 230 хувьцаа эзэмшигчдийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 19.8 тэрбум төгрөг байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮХЭХЗ-ЫН КОМПАНИУДЫН БАЙРШИЛ



БАЙРШИЛ

Нийт тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗ-ын байгууллагуудын 28.7 хувь нь Сүхбаатар, 24.5 хувь нь Хан-Уул, 16.2 хувь нь Чингэлтэй, 16.2 хувь нь Баянзүрх, 10.8 хувь нь Баянгол, 1.8 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт тус тус байршилтай бол хөдөө, орон нутагт 3 ҮХЭХЗ-ын байгууллага буюу 1.8 хувь нь байршиж байна.

ШИГТГЭЭ

Манай улсын үл хөдлөх хөрөнгийн салбар нь нийгэм, эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой салбарын нэгд зүй ёсоор тооцогддог бөгөөд үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа нь 2019 оны байдлаар нэрлэсэн ДНБ-ий 5.2 хувийг бүрдүүлж байна.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/



ШИГТГЭЭ


Олон улс дахь нэр томъёоллоор ҮХЭХЗ–чид нь үл хөдлөх эд хөрөнгийн гүйлгээг дамжуулах, худалдагч, худалдан авагчдыг хооронд нь зуучилж, тэднийг төлөөлөн хэлэлцээр хийдэг тусгай зөвшөөрөлтэй мэргэжилтнүүд юм. Үл хөдлөх эд хөрөнгийн зуучлагчид тухайн үл хөдлөх эд хөрөнгийн худалдан авах үнийн хувиас цалинждаг тул тэдний орлого гэрээг хэрхэн хийхээс бүрэн шалтгаалдаг.

Эх сурвалж: Investopedia, <https://www.investopedia.com/terms/r/realestateagent.asp>


**ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ,
ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ**

2020 онд давхардсан тоогоор 215 ҮХЭХЗ-ын байгууллага нийт 610.3 мянган м.кв талбай, 281.9 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан худалдан, худалдан авч, шилжүүлжээ.

Шимтгэлийн хэмжээ
/ҮХЭХЗ-ын байгууллагын тоогоор/




Талбайн хэмжээ
/ҮХЭХЗ-ын байгууллагын тоогоор/




**ТҮРЭЭСЛЭХ, ТҮРЭЭСЛҮҮЛЭХ, ХӨЛСЛӨХ,
ХӨЛСЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ**

2020 онд давхардсан тоогоор 126 ҮХЭХЗ-ын байгууллага нийт 88.6 мянган м.кв талбай, 39.9 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан хөлслүүлж, түрээслүүлжээ.

Шимтгэлийн хэмжээ
/ҮХЭХЗ-ын байгууллагын тоогоор/



Талбайн хэмжээ
/ҮХЭХЗ-ын байгууллагын тоогоор/



Жич: Түрээсийн шимтгэл сарын түрээсийн дүнд нэг удаа суутгагдсан болно.

АШИГТ АЖИЛЛАГАА

НИЙТ ХӨРӨНГӨ БА ЦЭВЭР АШИГ

2020 онд ҮХЭХЗ–ын байгууллагуудын нийт хөрөнгө 43.7 тэрбум төгрөг ба цэвэр ашиг 0.17 тэрбум төгрөг байна.

Санхүүгийн байдлын тайлангийн голлох үзүүлэлтүүд:

Эргэлтийн хөрөнгө

15.9

тэрбум төгрөг

Эргэлтийн бус хөрөнгө

27.8

тэрбум төгрөг



Өр төлбөр

24.0

тэрбум төгрөг

Эздийн өмч

19.7

тэрбум төгрөг

Орлого, үр дүнгийн тайлангийн голлох үзүүлэлтүүд:

НИЙТ ОРЛОГО
**20.8 ТЭРБУМ
ТӨГРӨГ**

НИЙТ ЗАРДАЛ
**20.6 ТЭРБУМ
ТӨГРӨГ**

ЦЭВЭР АШИГ
**0.17 ТЭРБУМ
ТӨГРӨГ**

Нийт ахиуц ашиг
42.0%

Цэвэр ахиуц ашиг
0.8%

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

o Дэлхийн банкны “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд тайлант хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн салбарын мэдээллийн сан үүсгэх, зуучлагчдын мөнгө угаах эрсдэлийг үнэлэх зориулалттай тоон мэдээлэл бүртгэлийн программ хангамжийн загвар гаргах, Зөвлөх үйлчилгээний үндсэн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор Дэлхийн банкны үндэсний /дотоодын/ зөвлөхтэй хэд хэдэн удаагийн уулзалтууд хийсэн. Энэхүү уулзалтаар үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын зохицуулалтыг бүртгэлжүүлэх, мэдээллийн сан үүсгэх системийн ажлын даалгавар боловсруулах ажлын хүрээнд ажлын шаардлагыг танилцуулж, холбогдох ажлын төлөвлөгөөг 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр баталсан.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

o “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ыг СЗХ-ны 2020 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тогтоолоор баталсан.

- o СЗХ-ны 181 дүгээр тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг баталсан.
- o СЗХ-ны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 121 дүгээр тогтоолоор үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоосон.
- o Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран ажиллаж СЗХ-ны зохицуулалтад хамрагдаж, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй үл хөдлөх эд хөрөнгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 6,728 хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын байцаагчийн 2020 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 4737 тоот дүгнэлтээр хүчингүй болгосон.
- o Монгол Улсын Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 90 дүгээр тушаалаар Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж тайлагнах үүрэг бүхий дэд ажлын хэсгүүдийг байгуулсан. Энэ хүрээнд Модуль 7 буюу санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын эмзэг байдлын үнэлгээг хийж, эрсдэлийн үнэлгээний тайлан боловсруулсан.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

o 2020 оны 10 дугаар сарын 30-нд Хууль зүйн яаман дээр төрийн байгууллагуудын төлөөлөл 12, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн төлөөлөл болон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбарын оролцогч нийт 16 иргэн оролцсон “Мөнгө угаах үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлангийн хэлэлцүүлэг”-ийг зохион байгуулсан бөгөөд тус хэлэлцүүлгээр 2 салбарын мөнгө угаах эрсдэлийн үнэлгээг дэлгэрэнгүй танилцуулж, эрсдэлийн үнэлгээ болон хуулийн эрх зүйн орчинг сайжруулах талаар санал авсан.



ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАР

Арилжаа эрхлэгчдийн тоо

30

Хуулийн этгээд



Салбарын төлөв

399

Иргэн

Худалдаж, худалдан
авсан үнэт металл

1.2

их наяд төгрөг




Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Нийт орлого

2.8

их наяд төгрөг



Ашигт ажиллагаа

Хүртээмжтэй байдал



83.2%

Улаанбаатар хотод үйл
ажиллагаа эрхэлж байна

Бодлого зохицуулалт



САЛБАРЫН ТӨЛӨВ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО:

СЗХ 2020 оны 5 дугаар сарын 06-ны өдрөөс үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож эхэлснээр 2020 оны байдлаар нийт 30 хуулийн этгээд, 399 иргэн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулдаг боллоо. Энэ нь 3 дугаар улирлын дүнгээс хуулийн этгээдийн тоо 13-аар, иргэдийн тоо 27-оор өссөн үзүүлэлт юм.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД

30



57

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА
ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ
ИРГЭД

111



231

ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУГААР
ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ
ИРГЭД

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Тусгай зөвшөөрөлтэй 30 хуулийн этгээдийн 46 хувьцаа эзэмшигчдийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 8.2 тэрбум төгрөг байна.


Салбарт үйл ажиллагаа эрхэлж буй нийт тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгчдийн 83.2 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 16.7 хувь нь хөдөө, орон нутагт байршиж байна.

Улаанбаатар хотод

83.2%

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ /БАЙРШЛААР/



Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид ихэвчлэн хөдөө, орон нутагт, харин тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид голчлон Улаанбаатар хотод байршсан. Тухайлбал үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн 56.8 хувь нь хөдөө, орон нутаг, 43.2 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

ӨМНӨГОВЬ 2
ДАРХАН-УУЛ 1
ГОВЬ-АЛТАЙ 2

Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

ХОВД 2
ДАРХАН-УУЛ 2

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч

БАЯНХОНГОР 14
СЭЛЭНГЭ 19
ТӨВ 11
ДАРХАН-УУЛ 4
ГОВЬ-АЛТАЙ 2
ӨМНӨГОВЬ 6
УВС 2
ДОРНОГОВЬ 1
ӨВӨРХАНГАЙ 1
ХОВД 3

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ХУДАЛДАЖ, ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ МЕТАЛЛЫН ДҮН


2020 онд нийт 577.0 тэрбум төгрөгийн үнэт металлыг худалдаж, 624.2 тэрбум төгрөгийн үнэт металлыг худалдан авчээ.



ШИГТГЭЭ: МОНГОЛБАНКНЫ АЛТ, МӨНГӨНИЙ СТАТИСТИК



Монголбанкны статистик мэдээгээр 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1 трой унци алтны үнэ 127,747.12 төгрөг, 1 трой унци мөнгөний үнэ 2,318.29 төгрөг байна.



Эх сурвалж: Монголбанкны статистик, Алт мөнгөний үнэ

ХУДАЛДАЖ, ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ДҮН




ШИГТГЭЭ: ДЭЛХИЙН ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТААМАГЛАЛ



Дэлхийн үнэт эдлэлийн зах зээлийн хэмжээ 2019 онд 330 тэрбум ам.доллар байсан бол 2027 он гэхэд 266.53 тэрбум ам.долларт хүрнэ гэсэн урьдчилсан таамаглалыг гаргаад байгаа юм.

Дэлхийн бүхий л улс оронд олон тооны хүмүүс өндөр орлоготойгоо илэрхийлэхдээ тансаг бүтээгдэхүүн хэрэглэх хандлагатай болсон тул үнэт эдлэлийн зах зээл өсөлт нэмэгдэх хандлагатай байна.

Ази Номхон далайн бүс нутгийн үнэт эдлэлийн зах зээлийн хэмжээ, 2016–2020



Эх сурвалж: fortunebusinessinsights.com

АШИГТ АЖИЛЛАГАА

НИЙТ ХӨРӨНГӨ БА ЦЭВЭР АШИГ

2020 онд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдүүдийн нийт хөрөнгө 18.4 тэрбум төгрөг ба цэвэр ашиг -0.13 тэрбум төгрөг байна.

Санхүүгийн байдлын тайлангийн голлох үзүүлэлтүүд:

Эргэлтийн хөрөнгө

11.4

тэрбум төгрөг

Эргэлтийн бус хөрөнгө

7.0

тэрбум төгрөг



Өр төлбөр

9.4

тэрбум төгрөг

Эздийн өмч

9.0

тэрбум төгрөг

Орлого, үр дүнгийн тайлангийн голлох үзүүлэлтүүд:

НИЙТ ОРЛОГО
**2.8 ТЭРБУМ
ТӨГРӨГ**

НИЙТ ЗАРДАЛ
**2.9 ТЭРБУМ
ТӨГРӨГ**

ЦЭВЭР АШИГ
**-0.13 ТЭРБУМ
ТӨГРӨГ**

Нийт ахиуц ашиг

61.5%

Цэвэр ахиуц ашиг

-4.7%

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ыг СЗХ-ны 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 150 дугаар тогтоолоор баталсан.
- СЗХ-ны 182 дугаар тогтоолоор “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг баталсан.
- СЗХ-ны 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 151 дүгээр тогтоолоор үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоосон.
- СЗХ-ны 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1048 дугаар тогтоолоор “Үнэт металл, үнэт чулууны эсхүл, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам”-ыг баталсан.
- Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран ажиллаж СЗХ-ны зохицуулалтад хамрагдаж, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулсан 230 аж ахуйн нэгжийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын байцаагчийн 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 4737 тоот дүгнэлтээр хүчингүй болгосон.
- Монгол Улсын Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 90 дүгээр тушаалаар Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж тайлагнах үүрэг бүхий дэд ажлын хэсгүүдийг байгуулсан. Энэ хүрээнд Модуль 7 буюу санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын эмзэг байдлын үнэлгээг хийж, эрсдэлийн үнэлгээний тайлан боловсруулсан.



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Дэлхийн банкны “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд тайлант хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн салбарын мэдээллийн сан үүсгэх, зуучлагчдын мөнгө угаах эрсдэлийг үнэлэх зориулалттай тоон мэдээлэл бүртгэлийн программ хангамжийн загвар гаргах, Зөвлөх үйлчилгээний үндсэн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор Дэлхийн банкны үндэсний /дотоодын/ зөвлөхтэй хэд хэдэн удаагийн уулзалтууд хийсэн. Энэхүү уулзалтаар үнэт металл, үнэт эдлэлийн салбарын зохицуулалтыг бүртгэлжүүлэх, мэдээллийн сан үүсгэх системийн ажлын даалгавар боловсруулах ажлын хүрээнд ажлын шаардлагыг танилцуулж, холбогдох ажлын төлөвлөгөөг 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр баталсан.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- СЗХ, Татварын ерөнхий газар хамтран байгуулсан “Мэдээлэл харилцан солилцох гэрээ”-ний хүрээнд Гааль татварын улсын үйлдвэрийн газрын дарга, мэргэжилтэнтэй 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр уулзаж, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийг И-Баримтын системд QR код нэвтрүүлэх, түүгээр тайлан мэдээ хүлээн авдаг болох цаашид хэрхэн хамтран ажиллах талаар харилцан санал солилцсон.
- Стандарт хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын газрын холбогдох албан хаагчидтай 2020 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр уулзаж, Сорьцын хяналтын өнөөгийн байдал, хамтарсан шалгалт болон сургалт хийх талаар ярилцаж, санал солилцсон.
- Монголбанкны Эрдэнэсийн сангийн холбогдох албан хаагчтай 2020 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр хамтран ажиллах тухай уулзалт хийсэн.
- “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын талаар Монголбанкны комплаенсын хэлтсийн холбогдох албан хаагчтай 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдөр уулзалт хийсэн.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2018	2019	2020
Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/	2,511.8	2,693.1	3,029.7
ЗЗҮ/ДНБ	7.8%	7.3%	8.2%
Хөрвөх чадвар	8.4%	5.0%	1.8%
Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/	210.3	133.7	53.9
Компанийн өрийн хэрэгслийн арилжаа /тэрбум төгрөг/	1.7	0.2	5.1
ЗГҮЦ–ны арилжаа /тэрбум төгрөг/	33.5	9.7	0.6
Хөрөнгө оруулалтын сан /тэрбум төгрөг/	–	–	5.4
ТОП–20 индекс	21,466.8	19,621.9	19,285.8
MSE А индекс	10,089.5	9,531.7	9,122.0
MSE Б индекс	8,727.94	7,950.7	7,581.1
ХК–ийн тоо	305	306	315
ҮЦК–ийн тоо	54	54	53
ХАА–н биржийн арилжааны дүн /тэрбум төгрөг/	711.4	705.1	488.7
МАРІХ	861,420.40	794,316.10	918,691.40

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2018	2019	2020
Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/	331.9	365.8	382.1
Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж /тэрбум төгрөг/	178.7	198.7	205.1
Нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/	58.2	65.5	59.8
Нөөц сан /тэрбум төгрөг/	146.0	165.6	173.5
Давхар даатгалын хураамж /тэрбум төгрөг/	54.5	57.3	66.8
Цэвэр ашиг /тэрбум төгрөг/	18.4	22.7	21
Мэргэжлийн оролцогчид:			
Ердийн даатгал	15	15	14
Урт хугацааны даатгал	1	1	1
Давхар даатгал	2	2	1
Даатгалын төлөөлөгч	2,430	2,520	2,473
Даатгалын зуучлагч	49	54	56
Хохирол үнэлэгч	27	27	25
Актуарч	28	30	32
Аудитор	141	144	145
Аудитын компани	43	44	45

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	2018	2019	2020
Нийт хөрөнгө	1,284.9	1,730.1	2,006.9
Эргэлтийн хөрөнгө	1,234.7	1,663.0	1,927.8
Мөнгөн хөрөнгө	315.1	364.0	491.5
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1.8	6.8	11.9
Нийт зээл	869.2	1,233.1	1,327.0
Хэвийн зээл	752.9	1,072.8	1,125.7
Хугацаа хэтэрсэн зээл	33.4	54.9	64.9
Чанаргүй зээл	82.9	105.4	136.4
Зээлийн эрсдэлийн сан	64.5	81.1	104.4
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	10.2	12.0	15.0
Эргэлтийн бус хөрөнгө	50.2	67.1	79.1
Нийт өр төлбөр	307.5	468.9	556.2
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	57.6	108.3	146.9
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	151.0	207.6	171.2
Төслийн зээлийн санхүүжилт	17.8	17.6	20.8
Эзэмшигчдийн өмч	977.4	1,261.2	1,450.7
Хоёрдогч өглөг	1.0	0.8	0.8
Хувьцаат капитал	740.8	927.0	1,017.7
Хуримтлагдсан ашиг	224.6	300.3	398.1
ББСБ-ын тоо	539	538	532
Үүнээс: УБ хот	464	463	455
Хөдөө, орон нутаг	75	75	77
Харилцагчдын тоо	1,423,597	2,348,014	2,844,782
Нийт орлого	259.5	352.9	408.8
Хүүгийн орлого	217.4	292.3	337.9
Хүүгийн бус орлого	33.5	53.9	62.2
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	8.6	6.8	8.5
Нийт зардал	158.4	212.8	254.0
Хүүгийн зардал	20.6	36.1	42.6
Хүүгийн бус зардал	96.0	118.0	148.0
Болзошгүй эрсдэлийн зардал	24.0	34.3	30.4
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	3.9	3.7	4.3
Цэвэр ашиг	101.1	140.2	154.8

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	2018	2019	2020
Нийт хөрөнгө	200.2	222.6	256.0
Эргэлтийн хөрөнгө	195.9	218.4	251.6
Мөнгөн хөрөнгө	57.9	57.6	77.7
Авлага	6.2	6.8	9.4
Эргэлтийн бус хөрөнгө	4.3	4.2	4.4
Үндсэн хөрөнгө /цэврээр/	4.2	4.0	4.1
Биет бус хөрөнгө	0.0	0.2	0.2
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0	0.0
Нийт зээл	133.8	156.7	167.6
Хэвийн зээл	123.4	143.3	154.7
Хугацаа хэтэрсэн зээл	4.4	7.3	5.5
Чанаргүй зээл	6.0	6.2	7.4
Өр төлбөр	166.7	179.7	206.5
Хадгаламж	141.5	155.8	182.2
Богино хугацаат зээл	5.5	3.8	3.0
Урт хугацаат өр төлбөр	7.6	5.5	5.9
Бусад богино хугацаат өр төлбөр	12.1	14.7	15.4
Өөрийн хөрөнгө	33.5	42.9	49.5
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	15.3	18.0	18.5
Хоршоологчдын өмч	18.0	24.7	30.7
Хуримтлагдсан орлого /алдагдал/	9.9	15.1	16.2
Нийт орлого	41.2	50.6	53.1
Хүүгийн орлого	39.6	48.4	50.5
Үйл ажиллагааны бусад орлого	0.8	1.0	1.0
Үйл ажиллагааны бус орлого	0.8	1.2	1.5
Нийт зарлага	35.9	41.5	43.9
Хүүгийн зардал	23.1	27.0	29.3
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	2.5	2.1	2.1
Үйл ажиллагааны зардал	9.5	11.1	11.5
Үйл ажиллагааны бус зардал	0.3	0.1	0.1
Цэвэр орлого	5.3	9.2	9.2
ХЗХ–дын тоо	290	261	249
УБ ХЗХ–дын тоо	192	164	148
Орон нутаг ХЗХ–дын тоо	98	97	101
Гишүүдийн тоо /мянга/	63	71	73

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

/Тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2018	2019	2020
Нийт хөрөнгө	70.3	105.5	147.1
Батлан даалтын үлдэгдэл	51.1	63.4	66.3
Үүнээс: Хугацаа хэтэрсэн	1.6	3.4	2.7
Чанаргүй	7.3	8.4	11.9
Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл	101.2	121.3	127.0
Үүнээс: Хугацаа хэтэрсэн	3.6	3.1	4.6
Чанаргүй	15.8	18.7	22.5
Үндсэн үйл ажиллагааны орлого	3.8	4.9	8.3
Үндсэн үйл ажиллагааны зардал	1.9	1.7	4.1
Үндсэн үйл ажиллагааны үр дүн	1.9	3.2	4.2
Олгосон батлан даалтын тоо	16	28	17
Үүнээс: Иргэдэд	3	1	0
Аж ахуйн нэгжид	13	27	17
Олгосон батлан даалтын дүн	30.8	20.9	13.5
Үүнээс: Иргэдэд	5.7	5.2	0.0
Аж ахуйн нэгжид	25.1	15.7	13.5
Үүнээс: Хөдөө аж ахуй	1.3	1.2	0.8
Үйлдвэрлэл	15.2	5.5	2.8
Бөөний болон жижиглэн худалдаа	6.0	4.8	5.7
Үйлчилгээ	7.9	9.4	4.2
Бусад	0.3	0.0	0.0
Батлан даалт гаргасан дундаж хугацаа /сараар/	97.4	89.6	88.5
Батлан даалт авахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	356	193	128
Үүнээс: Зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо	162	113	72

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2020.III	2020.IV
ҮХЭХЗ–ын байгууллагын тоо	140	167
Брокерын тоо	160	188
Агентын тоо	944	1171
Худалдаж, худалдан авч, шилжүүлсэн ҮХХ–ийн талбайн хэмжээ /м.кв/	150,583.2	163,059.00
Худалдаж, худалдан авч, шилжүүлсэн ҮХХ–ийн үнэ	131,318,249,284.2	101,325,031,690.0
Түрээслүүлж, түрээсэлж, хөлслүүлж, хөлсөлсөн ҮХХ–ийн талбайн хэмжээ /м.кв/	45,645.7	26,779.40
Түрээслүүлж, түрээсэлж, хөлслүүлж, хөлсөлсөн ҮХХ–ийн үнэ	5,587,217,277.9	2,318,251,015.1

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2020.III	2020.IV
Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо	17	30
Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн тоо	55	57
Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэдийн тоо	216	231
Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэгч иргэдийн тоо	101	111
Худалдан авсан үнэт металлын бохир жин /грамм/	3,068,535.1	4,079,924.3
Худалдан авсан үнэт металлын нийт үнэ	463,285,001,784.0	624,211,590,095.0
Худалдсан үнэт металлын бохир жин /грамм/	2,663,263.1	3,640,581.4
Худалдсан үнэт металлын нийт үнэ	416,652,693,549.1	576,920,753,040.0
Худалдан авсан эдлэлийн нийт үнэ	596,394,952.9	176,127,420.1
Худалдсан эдлэлийн нийт үнэ	1,009,188,348.9	194,105,540.0





Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia